



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: БНА-2025/001-НА-СТА

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор хот 2025 оны 04 дүгээр сарын 18-ний өдөр</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Аудитын менежер: М.Алтантуяа Утас: 70442424 Ахлах аудитор: Н.Батчимэг Утас: 99061861 Аудитор: Н.Бунчинсүрэн Утас: 99049866 Аудитор: Г.Энхзул Утас: 99333147 Аудитор: Ц.Дорж Утас: 88114307 Аудитор: Д.Оюун-Эрдэнэ Утас: 88916603</p>	<p>Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn Цахим хаяг: bunchisurenn@audit.gov.mn Цахим хаяг: enkhzulg@audit.gov.mn Цахим хаяг: dorjts@audit.gov.mn Цахим хаяг: oyun-erdened@audit.gov.mn</p>
--	--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<p>Тайланг хянасан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат</p> <p>Аудитын менежер М.Алтантуяа</p> <p>Тайланг бэлтгэсэн Ахлах аудитор Н.Батчимэг</p> <p>Аудитор Н.Бүнчинсүрэн Г.Энхзул Ц.Дорж</p> <p>2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр</p> <p>Уг тайланг УАГ-ын Цахим хуудаснаас үзнэ үү: www.open.audit.mn</p> <p>Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.</p> <p>ХАЯГ: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар Аймгийн ЗДТГ-ын байр, Баянхонгор сум, Баянхонгор аймаг-64000 Монгол Улс</p>	<p>АГУУЛГА</p> <p>Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл.....3</p> <p>Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх 3</p> <p>Аудитын зорилт 3</p> <p>Аудитын хамарсан хүрээ 3</p> <p>Аудитын арга зүй..... 4</p> <p>Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт..... 4</p> <p>Аудитыг гүйцэтгэсэн хугацаа, аудитын багийн бүрэлдэхүүн 4</p> <p>Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл, хэлэлцүүлсэн журам 4</p> <p>Товчилсон үгийн тайлбар 5</p> <p>ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ 5</p> <p>БҮЛЭГ 1. “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-той уялдуулан баталсан аймгийн Засаг даргын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хараахан эхлээгүй байгаа тул зорилтуудын хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна.....6</p> <p>1.1.Бүсчилсэн хөгжлийн бодлого.....6</p> <p>1.2.Баянхонгор аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө.....7</p> <p>БҮЛЭГ 2. Төрийн албан хаагчдын цалингийн өсөлт болон “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2024 оны ногдол ашиг хуваарилсан зэрэг нь татварын орлого 6,043.6 сая төгрөгөөр давуулан биелэхэд голлон нөлөөлсөн байна.....9</p> <p>2.1.Татварын болон татварын бус орлогын төлөвлөлт, гүйцэтгэл.....11</p> <p>2.1.1.Татварын орлого.....11</p> <p>2.1.2.Татварын бус орлого.....14</p> <p>БҮЛЭГ 3 Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу, сумдын Засаг дарга нарын гүйцэтгэлийн тайланд хөтөлбөрийн зорилт, үр дүнг тоон болон чанарын шалгуураар тодорхойлж, цаашдын хэрэгжилтэд хяналт тавих шаардлагатай байна.....16</p> <p>3.1.Хөтөлбөр арга хэмжээ, хүрэх үр дүн.....16</p> <p>3.2.Батлагдсан төсөв.....19</p> <p>3.3.Зардлын гүйцэтгэл.....20</p> <p>3.3.1.Орон нутгийн хөгжлийн сан.....23</p> <p>3.3.2.Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал.....24</p> <p>3.3.3.Их засвар.....24</p> <p>3.3.4.Техник хяналт, барьцаа хөрөнгө оруулалт.....25</p> <p>3.3.5.Замын сан.....26</p> <p>3.3.6.Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал.....26</p> <p>3.3.7.Хоршоо хөгжүүлэх сан.....27</p> <p>БҮЛЭГ 4 ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛИЙН СУДАЛГАА.....28</p> <p>БҮЛЭГ 5. ЗАРИМ АЛБАН ТУШААЛТАН ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ МӨРДӨЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.....35</p> <p>5.1.Төрийн хэмнэлтийн хуулийн 6 дугаар зүйл.Тээврийн хэрэгсэл.....35</p> <p>5.2.Төрийн хэмнэлтийн хуулийн 8 дугаар зүйл. Дүрэмт хувцас.....36</p> <p>5.3.Төрийн хэмнэлтийн хуулийн 12 дугаар зүйл. Бусад хангамж.....36</p> <p>5.4.Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйл.Хэмнэлтийн бусад арга хэмжээ37</p> <p>БҮЛЭГ 6. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬ.....37</p> <p>6.1.Засаг даргын Шилэн дансны хуулийн хэрэгжилт.....37</p> <p>6.2.СТА-аар илэрсэн Шилэн дансны зөрчил.....38</p> <p>БҮЛЭГ 7. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ТӨЛБӨРИЙН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.....39</p> <p>БҮЛЭГ 8. БАЯНХОНГОР АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ АЙМГИЙН ИТХ ХҮЛЭЭН АВСАН БАЙНА.....41</p> <p>АУДИТЫН ДҮГНЭЛТ.....42</p> <p>АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....42</p> <p>УАГ-ын САНХҮҮ -Нийцлийн аудитын газарт хүргүүлэх санал.....43</p>
--	---

**Аудит хийсэн
үндэслэл, бүрэн
эрх****Аудитын зорилт****Аудитын хамарсан
хүрээ****АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ
МЭДЭГДЭЛ**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5¹-д заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай” 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/52, А/52-1 дугаар тушаал, газрын дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/02 дугаар тушаалыг үндэслэн Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг шалгаж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж дүнг Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, холбогдох албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд

- Орон нутгийн төсвийг төсвийн бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого, жилийн хөгжлийн бодлоготой нийцүүлэн төлөвлөж, хэрэгжилтийг хангасан эсэх,
- Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн орлогыг бодитой төлөвлөж, төвлөрүүлсэн эсэх,
- Аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн орлого, зарлагыг зүй зохистой, үр ашигтай байдлаар Төсвийн тухай хуулийн 54.5-т заасан бүрэлдэхүүнээр гарган, хэрэгжүүлж хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтод түвшинд нийцсэн эсэх.
- Орон нутгийн төсвийн байгууллагуудаас ерөнхий чиглэлийн дагуу авсан судалгааны нэгтгэл, үр дүн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжүүлэн ажилласан эсэх
- Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн ажилласан эсэх,
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан эсэх,
- Баянхонгор аймгийн 2024 оны төсвийн төсөлд өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлсэн эсэх.

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, аймгийн Татварын газрын аудитад хамрагдах татварын төлөвлөгөө, тайлан, Сангийн яамнаас Баянхонгор аймгийн 2024 оны аймгийн төсвийн суурь, орлого зарлагыг хянаж ирүүлсэн тооцоо болон бусад материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

¹8.9.4.аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020, MNS 6817-4:2020 “Төрийн аудит. Санхүүгийн аудит”, 6817-6 :2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, МУЕА-ын 2021 оны А/71 тушаал “Заавар аргачлал батлах тухай” журмын аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2024 оны төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Тусгай сангийн тухай хууль
- ТБОНӨТХ
- ТБОНӨБАҮХАТХ
- Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”
- Төрийн аудитын байгууллагаас 2024-2025 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл
- Баянхонгор аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолууд
- Холбогдох бусад хууль тогтоомж

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа, аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер М.Алтантуяа үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Батчимэг ахалж, аудитор Н.Бүнчинсүрэн, Г.Энхзул, Ц.Дорж нар 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн 2025 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл, хэлэлцүүлсэн журам

Аудитын тайланг үндсэн мэдээлэл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж гэсэн агуулгаар бичиж, аудитын тайланд аудитын менежер, тэргүүлэх аудитор нараар үе шатны хяналт хийлгэж, аудитын тайланг ҮАГ-ын Санхүү, нийцлийн аудитын газар, Баянхонгор аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах Баянхонгор аймгийн орон тооны байнгын ажлын хэсэг, Баянхонгор аймгийн Татварын газарт хүргүүлэв.

	Товчилсон үгийн тайлбар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт
АТӨЯХАТ	Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ЖХТ	Жилийн хөгжлийн төлөвлөгөө
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
НҮТББ	Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХШҮХ	Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай, Төрийн албаны тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Татварын ерөнхий хуулиудад нэмэлт, өөрчлөлт орсон, УИХ-аас Төсвийн тухай хуульд 8 удаа нэмэлт өөрчлөлт орсон, Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон, 82 дугаар тогтоолоор төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам, 83 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг тус тус баталсан байна.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн төсөлд тусгагдсан төсвийн суурь орлогыг 3,245.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх 7 санал, суурь зарлагыг 790 сая төгрөгөөр бууруулах 1 санал, төсвийн үр ашгийг 2,480.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх 5 санал, нийт 6,515.4 сая төгрөгийн 13 саналыг хүргүүлснийг хүлээн авсан байна.

Баянхонгор аймгийн Засаг даргаас 2024 оны төсвийн төсөлд төсвийн орлогыг 18,867.4 сая төгрөгөөр төлөвлөн Сангийн яаманд хүргүүлснийг 787.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 19,655.1 сая төгрөгөөр хянасан, Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Сангийн яамны хянасан дүнг 126.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 19,781.5 сая төгрөгөөр баталжээ. Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн тодотголоор нийт орлогыг 4,798.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 24,580.3 сая төгрөгөөр баталжээ.

Баянхонгор аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолоор Баянхонгор аймгийн нийт төсвийг 101,382.0 сая төгрөгөөр баталсныг тодотголоор 7,403.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 108,785.8 сая төгрөгийн орлогын эх үүсвэрийг баталсан байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 17/52 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны нийт төсвийн эх үүсвэрийг 67,444.4 сая төгрөгөөр, аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар 3,158.2 сая төгрөгөөр бууруулж, нийт төсвийг 64,286.2 сая төгрөгөөр шинэчлэн баталсан байна.

Тайланд онд аймгийн татварын орлогоор 32,158.4 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс 38,202.0 сая төгрөг оруулж, орлогын төлөвлөгөөг 6,043.6 сая төгрөгөөр буюу 18.8 хувиар давуулан биелүүлжээ.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны нийт зарлагыг 108,785.8 сая төгрөг баталснаас гүйцэтгэлээр 91,829.2 сая төгрөгийг зарцуулж, 16,956.6 сая төгрөг зарцуулагдаагүй байгаа нь төлөвлөсөн хандивын орлого бүрэн төвлөрөөгүй, 13 сумын Хоршоо хөгжүүлэх сан тайлант онд төлөвлөсөн хөнгөлөлттэй зээлийг олгоогүй, төлөвлөсөн зардлыг хэмнэж ажилласан зэрэгтэй холбоотой байна.

АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1. “БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО”-ТОЙ УЯЛДУУЛАН БАТАЛСАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024–2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАРААХАН ЭХЛЭЭГҮЙ БАЙГАА ТУЛ ЗОРИЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.

1.1. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолоор 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласан ба "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хэрэгжүүлэх, хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулах, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийн хэлэлцүүлгийг хөгжлийн бүс тус бүрээр болон нэгдсэн байдлаар 2024 оны 01 дүгээр улиралд багтаан зохион байгуулах ажил тусгагдсан.

Тус ажлын хүрээнд бүсчилсэн хөгжлийн хэлэлцүүлгийг Баянхонгор, Өвөрхангай, Архангай аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, төрийн захиргааны бусад албан хаагчдыг хамруулан анхны хэлэлцүүлгийг Өвөрхангай аймагт 2024 оны 01 дүгээр сард зохион байгуулсан байна. Тус хэлэлцүүлгээр дараах санал, санаачилга гарсан байна. Үүнд:

- Архангай, Баянхонгор аймгийг хатуу хучилттай авто замаар холбох
- Аялал жуулчлал, дэд бүтцийн чиглэлээр тодорхой үр ашигтай хамтран ажиллах
- Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж байгаа ХААИС-ийн салбар сургуулийг өргөтгөн бүсийн болон хөрш зэргэлдээх аймгуудын хөдөө, аж ахуйн салбарын мэргэшсэн боловсон хүчин бэлтгэж, ажлын байраар хангах зэрэг бүсчилсэн урт хугацааны төлөвлөлтийг хийх санал гарсан байна.

Мөн “Монгол Улсын эдийн засгийн чуулган-Бүсчилсэн хөгжлийн зөвлөгөөн” 2024 оны 02 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарын бүрэлдэхүүнтэй нийт 50 гаруй төлөөлөл, 2024 оны 10 дугаар сард “Бүсчилсэн хөгжлийн үндэсний чуулган”-д АЗДТГ-ын алба хаагчид бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцсон байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4/20 дугаар тогтоолоор “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан байна.

Уг хөтөлбөрийн нэг дүгээр бүлэгт “БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО”-ыг тусгасан ба салбарын үр дүнг “Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ”, Засаг даргын үр дүнг “**Уламжлалт мал аж ахуй, аялал жуулчлалын төрөлжсөн бүс болно**” гэж тодорхойлон 10 зорилтыг тусгасан байна. Үүнд:

- Хангайн болон Баруун бүсийн аймгуудыг нэгтгэсэн тээвэр логистикийн төвийг Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсэд байгуулж, орон нутгийн иргэдийн жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээг өргөжүүлэх замаар бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлнэ.
- Байдрагийн голыг түшиглэн 30 мВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станцыг ашиглалтад оруулж, Хангайн бүсэд байгаль орчинд ээлтэй, ногоон эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгоно./үе шаттайгаар/
- Хангайн бүсийн аймгуудыг хатуу хучилттай авто замаар холбож, аялал жуулчлалын шинэ маршрут бий болгон байгалийн болон түүх соёл, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн 54,8 км хатуу хучилттай автозамыг ашиглалтад оруулж, Шаргалжуут болон бага Шаргалжуутын рашаан сувиллыг түшиглэн эрүүл мэндийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- Үндэсний өв, нүүдлийн соёлыг түгээн дэлгэрүүлж, орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн шашин, соёл, спорт, тусгай сонирхлын зэрэг дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- Аялал жуулчлалын гадаад, дотоодын маркетинг, сургалт, сурталчилгааг өргөжүүлнэ.
- Улсын чанартай авто зам дагуу ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн коллежийг түшиглэн дадлага, үйлдвэрлэлийн бааз байгуулна.
- Ингэний сүүний үйлдвэрийн үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр эрчимжүүлж, экспортын гол нэрийн бүтээгдэхүүнийг бий болгоно.
- Бүс нутгийн онцлогт тохирсон цөм сүргийг үржүүлэх ажлыг зохион байгуулна.

Аймгийн Засаг даргын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр нь хэрэгжилтийн хугацаа нь хараахан эхлээгүй байгаа тул тайлант онд хэрэгжилт гараагүй болно.

1.2.Баянхонгор аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/26 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу Баянхонгор аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулсан байна. Энэхүү төлөвлөгөө нь хууль, аргачлалын хүрээнд боловсруулагдсан бөгөөд бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн уялдаа, хэрэгжилтийг хянан үнэлэх үндэслэл болж байна.

Баянхонгор аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 17/59 дугаар тогтоолоор баталж, салбарын 24 үр дүн, төсвийн ерөнхийлөн захирагчийн 38 үр дүн, хөтөлбөрийн 52 үр дүнгийн хүрээнд нийт 250 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг санхүүжүүлэх эх үүсвэр дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 1. Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний нэгтгэл (сая төгрөг)

Төсөв арга хэмжээний санхүүжүүлэх эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний тоо	Санхүүжүүлэх дүн
Аймаг, сумын ОНХС-ын хөрөнгөөр	97	11,891.4

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар	42	141,417.1
Их засварын зардлын эх үүсвэрээр	38	3,176.5
Хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар	60	1,747.4
Аймгийн ХЭДС	2	-
Боловсролын яамны тэтгэлэг	1	800.0
Байгууллагын төсөв	1	1.0
Байгаль орныг хамгаалах нөхөн сэргээх арга, хэмжээний зардал	10	217.5
Замын сан	16	1,766.3
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар	1	814.1
Бусад эх үүсвэр	3	305.5
НИЙТ	271	162,136.7

Эх сурвалж: Баянхонгор аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө

Аймгийн ИТХ-аар тодотгон баталсан тогтоолд аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал, замын сан, ОНХС, их засвар, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 18,996.3 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр тусгасан байхад хөгжлийн төлөвлөгөөнд 18,799.1 сая төгрөгөөр буюу 197.2 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна.

Хүснэгт 2. Аймгийн ИТХ-ын тогтоол, 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний харьцуулалт (сая төгрөг)

№	Төсөл, арга хэмжээ	Аймгийн ИТХ-ын тодотгосон тогтоол		Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө		Зөрүү	
		Тоо	Санхүүжилт	Тоо	Санхүүжилт	Тоо	Санхүүжилт
1	Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал	59	1,896.4	60	1,747.4	-1	149.0
2	Замын сангийн хөрөнгө	16	1,718.7	16	1,766.3	-	-47.6
3	ОНХС-ийн зардал	100	12,107.2	97	11,891.4	3	215.8
4	Их засварын зардал	37	3,046.5	38	3,176.5	-1	-130.0
5	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал	10	227.5	10	217.5	-	10.0
		222	18,996.3	221	18,799.1	1	197.2

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол, 2024 оны хөгжлийн төлөвлөгөө

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Баянхонгор аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 17/57 дугаар тогтоолоор аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 250 төсөл, арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 1,758.0 сая төгрөг баталж, 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн “Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж батлах тухай” 21/07 дугаар тогтоолоор 134.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 270 төсөл, арга хэмжээг 1,896.4 сая төгрөгөөр төгрөгөөр санхүүжүүлэхээр тодотгожээ.

Аймгийн ИТХ-аар тодотгон баталсан хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал 1,896.4 сая төгрөг ба хөгжлийн төлөвлөгөөнд 1,747.4 сая төгрөгөөр буюу 149.0 сая төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын тодотгон баталсан тогтоолоор аймгийн ЗДТГ-ын ажлын албанд шаардлагатай автомашинд 266.8 сая төгрөгийг баталсан байхад хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй.
- Аймгийн ИТХ-ын тодотгон баталсан тогтоолд батлагдаагүй Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах 16-р ангийн өндөр барилгад гарсан гал түймэр, аваар ослын үед ашиглах автомеханик шатны тусгай зориулалтын автомашиныг шийдвэрлэх 100.0 сая, мөн төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллогыг чанартай зохион байгуулж, дүнг нэгтгэх 12.0 сая, нийт 112.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан.
- Аймгийн ИТХ-ын тодотгон баталсан тогтоолд хамтын ажиллагаатай улс, орнуудтай олон талт уулзалт зохион байгуулж, сайн туршлагыг орон нутагт

хэрэгжүүлэх арга хэмжээг 34.2 сая төгрөгийг баталсан байхад аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд 40.0 сая төгрөг буюу 5.8 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна.

Аймгийн ИТХ-ын төсөв баталсан тогтоол, аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг зөрүүтэй баталж байгаа асуудлыг анхаарч үзэхийг аймгийн ИТХ-д толилуулав.

Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгагдсан 3 төсөл, арга хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6,161.7 сая, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 57.0 сая төгрөгийг тусган хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Баянхонгор- Шаргалжуут чиглэлийн 54.8 км хатуу хучилттай автозамыг ашиглалтад оруулж, Шаргалжуут болон бага Шаргалжуутын рашаан сувиллыг түшиглэн эрүүл мэндийн аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын хүрээнд улсын төсөвт 6,161.7 сая төгрөг суугдаж 2024 онд авто замын далангийн суурийн ажил, хоолойн ажлууд хийгдсэн ба эрх шилжээгүй хөрөнгө оруулалт тул гүйцэтгэл гарах боломжгүй байна.
2. Аялал жуулчлалын гадаад, дотоодын маркетинг, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх ажлын хүрээнд хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 20.0 сая төгрөг тусгаж “Монголын тэмээн сүргийн соёл” улсын зөвлөгөөн, Олон улсын “Торгоны зам” автомашины ралли уралдаан, мөн хангай чиглэлийн тусгай сонирхлын аяллын маршрут болох хадны сүг зураг сонирхох судалгааны аяллын маршрут, хөтөлбөр гаргасан байна.
3. Бүс нутгийн онцлогт тохирсон цөм сүргийг үржүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд Шинэжинст сумын Залаа Жинстийн цагаан ямааны цөм сүргийг сайжруулахад ОНХС-аас 20.0 сая төгрөгийг тусган цөм сүргийг сайжруулах судалгааны ажилд зарцуулсан байна.

Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс 78.5 хувьтай тайлагнасан байна.

Хүснэгт 3. Аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Үзүүлэлт	Салбарын үр дүн	Засаг даргын үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Үндсэн үйл ажиллагаа, хөтөлбөр арга хэмжээ
Нийт дүн (тоо)	25	39	52	271
Үр дүнтэй "100 хувь"	9	25	26	179
Тодорхой үр дүнд хүрсэн "70-90 хувь"	2	9	17	26
Эрчимжүүлэх шаадлагатай "30-70 хувь"	2	3	6	26
Үр дүнгүй "0-30 хувь"	4	2	2	40
Үнэлэх боломжгүй	8	0	1	0
Дундаж хэрэгжилт (хувь)	68.0	87.5	84.3	78.5

Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ийн ЖХТ-ний тайлагнал

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх тухай” 6/10 дугаар тогтоолоор аймгийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 87.5 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн байна.

БҮЛЭГ 2. ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ЦАЛИНГИЙН ӨСӨЛТ БОЛОН "ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХК-ИЙН 2024 ОНЫ НОГДОЛ АШИГ ХУВААРИЛСАН ЗЭРЭГ НЬ ТАТВАРЫН ОРЛОГО 6,043.6 САЯ ТӨГРӨГӨӨР ДАВУУЛАН БИЕЛЭХЭД ГОЛЛОН НӨЛӨӨЛСӨН БАЙНА.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Баянхонгор аймгийн Засаг дарга Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний дагуу санхүүгийн дэмжлэгээр 34,182.5 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 21,577.0 сая, нийт тусламж санхүүжилтийн орлогыг 55,759.5 сая төгрөгөөр баталсан байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс Сангийн яаманд татварын орлогыг 17,187.4 сая, хүү, торгуулийн орлогыг 1,680.0 сая, нийт 18,867.4 сая төгрөгөөр төлөвлөж хүргүүлснийг Сангийн яам татварын орлогыг 17,975.1 сая, татварын бус орлогыг 1,680.0 сая төгрөг, нийт 19,781.5 сая төгрөгийг оруулахаар хянаж баталсан байна. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Сангийн яамны хянасан дүнг 4,798.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нэмэгдүүлэн 24,580.3 сая төгрөгөөр баталжээ.

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны 21/06 дугаар тогтоол, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор аймгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 32,158.4 сая төгрөг, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 34,182.5 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох дэмжлэг 21,577.0 сая, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 128.8 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 507.7 сая, бусад эх үүсвэрийн орлого (техник хяналт) 500.0 сая, тусламжийн орлогоор 5,857.9 сая, урьд оны үлдэгдлээс 9,401.7 сая, хөрөнгийн орлогоор 508.2 сая, газрын тосны орлогоор 42.4 сая, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 1,589.3 сая, урьд оны үлдэгдлээс 9,638.8 сая, хүү, торгуулийн орлогоор 2,095.1 сая, нийт эх үүсвэр 108,785.8 сая төгрөгөөр, 2024 онд аймгийн төсвөөс зарцуулах зарлагыг нийт 108,785.8 сая төгрөгөөр баталжээ.

СТА-аар Бууцагаан сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Бууцагаан сумын 2024 оны төсөв батлах тухай” 13/07 дугаар тогтоолоор сумын нийт орлогыг 2,713,321.0 мянга, нийт зардлыг 2,712,495.7 мянган төгрөгөөр баталж орлого, зарлагыг 825.3 мянган төгрөгөөр зөрүүтэй баталсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

ОНХНС-аас аймагт 7,631.3 сая, сумдад 13,945.7 сая, нийт 21,577.0 сая төгрөгийг олгохоос тайлант онд 20,790.0 сая төгрөгийг олгож, 787.0 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон ба энэ нь улсын төсөвт төвлөрдөг татварын орлого тасарсантай холбоотой байна.

Хүснэгт 4. Аймгийн 2024 оны төсвийн суурь зарлагын эх үүсвэр (сая.төг)

Үзүүлэлт		Баянхонгор аймаг		
		Өмнөх оны гүйцэтгэл	2024 он	
			Анх батлагдсан	Тодотгосон төсөв
А		1	2	3
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО		69,552.7	101,382.0	108,785.8
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		69,552.7	101,382.0	108,785.8
А	УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	27,477.0	37,888.6	42,803.7
	1 Татварын орлого	23,644.6	24,831.7	32,158.4
	2 Татварын бус орлого	3,832.4	10,056.9	10,645.3
Б	ХӨРӨНГИЙН ОРЛОГО	677.2	508.2	508.2
В	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	41,398.6	59,082.2	55,759.5
Г	ӨМНӨХ ОНЫ ХЭМНЭГДСЭН ЗАРДАЛ, ТЭНЦЛИЙН АШГААС			
Д	ӨМНӨХ ОНЫ ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ		3,740.3	6,304.9
Е	СУМДЫН ТУСГАЙ САНГУУД		3,162.8	3,409.5
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		69,931.0	101,382.0	108,785.8
А	УРСГАЛ ЗАРЛАГА	46,804.4	101,382.0	108,785.8
	1 Бараа үйлчилгээний зардал	44,803.4	63,097.9	68,458.0
	2 Зээлийн үйлчилгээний төлбөр			
	3 Татаас ба урсгал шилжүүлэг	2,001.0	60.0	60.0
Б	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,463.5	33,574.1	35,575.3
В	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	663.1		

УРСГАЛ ТЭНЦЭЛ	-19,327.4	-32,919.4	-30,406.8
НИЙТ ТЭНЦЭЛ	-378.3	0.0	0.0

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Баянхонгор аймаг, сумын ИТХ-ын тогтоолууд

2.1.Татварын болон татварын бус орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар аймаг, сумдын ИТХ-аар 108,785.8 сая төгрөгийн нийт эх үүсвэрийг баталж, гүйцэтгэлээр санхүүгийн дэмжлэг болон орон нутгийн төсвөөс 71,216.3 сая, ОНХНС-аас авсан санхүүжилт 20,790.0 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,669.5 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 454.6 сая, тусламжийн орлого 2,510.7 сая, нийт 96,641.1 төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

2.1.1.Татварын орлого

Тайланд онд татварын орлогыг 32,158.4 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 38,202.0 сая төгрөгийг оруулан төлөвлөгөөг 6,043.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 5. Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлт (сая.төг)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Орлогын албан татвар	32,158.4	38,202.0	6,043.6	118.8
Хувь хүний орлогын албан татвар	22,102.7	27,069.2	4,966.5	122.5
Хөрөнгийн албан татвар	2,853.4	2,856.9	3.5	100.1
Бусад татвар, төлбөр, хураамж	7,202.3	8,275.9	1,073.6	114.9

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Баянхонгор аймгийн Засаг даргын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг аймгийн Татварын газрын аймгийн төсвийн болон сумдын төсвийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг аудитын явцад тулган шалгахад аймгийн Татварын газрын орлого 38,514.0 сая төгрөгөөр тайлагнаж, төсвийн гүйцэтгэлийн тайлангаас 312.0 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Татварын газар хувь хүний буцаалтын 1,050.0 сая, бусад татварын 500.0 сая, газрын дуудлага худалдааны орлогын 149.2 сая төгрөгийг төлөвлөгөөнд оруулдаггүй, мөн татварын орлогын гүйцэтгэлд замд яваа мөнгө хөрөнгө 88.7 сая төгрөгийг оруулан тооцсонтой холбоотой байна.

Тайлант онд төлөвлөсөн 32,158.4 сая төгрөгийн татварын орлогыг 38,202.0 сая биелүүлснээс цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхэлсний орлого 116.7 хувь, үйл ажиллагааны орлого 149.3 хувь, хөрөнгийн орлого 120.1 хувь, ААН-ийн орлогын албан татвар 140.3 хувь, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 105.3 хувь, галт зэвсгийн албан татвар 108.5 хувь, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 111.9 хувь, улсын тэмдэгтийн хураамж 224.7 хувь, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 230.0 хувь, хог хаягдлын үйлчилгээний хураамж 104.6 хувь, бусад татвар 105.8 хувь, газрын төлбөр 103.6 хувь, газрын дуудлага худалдааны орлого 121.2 хувь, ан амьтны нөөц ашигласны төлбөр 102.6 хувиар тус тус давуулан биелүүлжээ.

Хүснэгт 6. Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая.төг)

Код	Үзүүлэлт	2024 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
11	ТАТВАРЫН ОРЛОГО	32,158.4	38,202.1	6,043.7	118.8
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхэлсний орлого	16,503.9	19,256.3	2,752.4	116.7
110002	Үйл ажиллагааны орлого	3,675.7	5,487.7	1,812.0	149.3
110003	Хөрөнгийн орлого	1,392.1	1,672.0	279.9	120.1
110004	Хөрөнгө борлуулсны орлого	891.0	735.2	-155.8	82.5

110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,049.9)	(1,049.9)	0.0	100.0
110301	ААН-ийн орлогын албан татвар	690.0	967.9	277.9	140.3
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	658.5	693.7	35.2	105.3
113002	Галт зэвсгийн албан татвар	76.5	83.0	6.5	108.5
113003	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	650.0	727.3	77.3	111.9
113004	Малд ногдуулах албан татвар	1,468.4	1,352.9	-115.5	92.1
118001	Улсын тэмдэгтийн хураамж	358.5	447.2	88.7	124.7
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	220.0	506.0	286.0	230.0
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,571.2	1,643.1	71.9	104.6
118011	Бусад татвар	340.0	359.8	19.8	105.8
118101	Газрын төлбөр	767.5	795.2	27.7	103.6
118102	Дуудлага худалдаа	123.1	149.2	26.1	121.2
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	3,126.3	3,208.2	81.9	102.6
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	695.3	663.7	-31.6	95.4
118301	Бусад татвар	0.3	503.6	503.3	165,749.3

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төлөвлөгөөнөөс давж биелсэн татварын орлогод дүн шинжилгээ хийхэд дараах хүчин зүйл голлох нөлөөг үзүүлсэн байна. Үүнд:

- Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татварыг 16,503.9 сая төгрөгөөр төлөвлөж, 2,752.4 сая төгрөгөөр давж биелэн 19,256.3 сая төгрөгийн татвар төсөвт төвлөрсөн нь 2024 онд Засгийн газрын 128 дугаар тогтоолоор зарим төрийн албан хаагчдын цалингийн шатлалыг өөрчилж, нэмэгдүүлсэн, 82 дугаар тогтоолоор төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгодог болсноос шалтгаалсан байна.

- Үйл ажиллагааны орлогыг 3,675.7 сая төгрөгөөр төлөвлөж, 1,812.1 сая төгрөгөөр давж биелэн 5,487.7 сая төгрөгийн татвар төсөвт төвлөрсөн нь “Эрдэнэс Тавантолгой” ХК ийн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ногдол ашгийг иргэн бүрд олгосонтой холбоотой байна.

- Хөрөнгийн орлогыг 1,392.1 сая төгрөгөөр төлөвлөж, 279.9 сая төгрөгөөр давж биелэн 1,672.0 сая төгрөгийн татвар төсөвт төвлөрсөн нь хадгаламж хуримтлал нэмэгдсэнтэй холбоотой байна.

- ААН-ийн орлогын албан татварыг 690.0 сая төгрөгөөр төлөвлөж, 277.9 сая төгрөгөөр давж биелэн 967.9 сая төгрөгийн татвар төсөвт төвлөрсөн нь татвар төлөгч ААН-ийн тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.

- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 658.5 сая төгрөгөөр төлөвлөн, гүйцэтгэлээр 693.7 сая төгрөгийг оруулсан нь тайлант онд иргэдийн худалдан борлуулсан үл хөдлөх хөрөнгөөс холбогдох хуулийн хүрээнд ногдуулалт хийсэнтэй холбоотой байна.

- Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг 650.0 сая төгрөгөөр төлөвлөж, 77.3 сая төгрөгөөр давж биелэн 727.3 сая төгрөгийн татвар төсөвт төвлөрсөн нь өмнөх оны өр төлбөрийг төлүүлэхэд анхаарч ажилласантай холбоотой байна.

- Улсын тэмдэгтийн хураамж тайлант онд 358.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 88.72 сая төгрөгөөр давж биелэн 447.22 сая төгрөг орсон нь Бууцагаан сум, Баянцагаан сумууд төлөвлөгөөг давуулан биелүүлсэнтэй холбоотой байна.

- Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тайлант онд 220.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 289.0 сая төгрөгөөр давж биелэн 506.0 сая төгрөг орсон нь Шинэжинст суманд үйл ажиллагаа явуулж хийж байгаа аж ахуйн нэгжүүд татварыг өндөр төлсөнтэй холбоотой байна.

- Хог хаягдлын хураамжийн орлого өмнөх жилүүдтэй харьцуулахад төлөвлөсөн хураамжийг давуулан биелүүлсэн нь хог хаягдлын хураамжийг цахилгааны төлбөр дээр нэмж төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

- Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 3,126.3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 3,208.19 сая төгрөгийг сумын төсөвт төвлөрүүлж 81.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн нь Монгол Улсын Засгийн газрын 2024.03.06-ны өдрийн “Тусгай зориулалтаар 2024 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай” 89 дүгээр тогтоолоор Баянхонгор аймагт угалз, тэх, халиун буга агнах шийдвэр гарсан, мөн шонхор шувууг барих зөвшөөрлийн гэрээг олон тоогоор байгуулсантай холбоотой байна.

Тайлант онд орлогын төлөвлөгөө биелээгүй татварыг нэр төрлөөр нь авч үзвэл дараах орлогууд тасарсан байна. Үүнд:

- Хөрөнгө борлуулсны орлогыг 891.0 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 735.2 сая төгрөгийн орлого төвлөрч 155.8 сая төгрөгийн орлого биелээгүй нь Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогын албан татварын үнийг тухайн иргэд өөр хоорондоо худалдан борлуулдагтай холбоотой байна.

- Ус, рашааны нөөц ашигласны төлбөр тайлант онд 695.3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 663.7 сая төгрөг төвлөрч 31.6 сая төгрөгөөр орлого тасарсан нь Шинэжинст сум, Баянцагаан сум, Баянхонгор аймаг төлөвлөгөөгөө биелүүлээгүйтэй холбоотой байна.

- Малын тоо толгойн албан татварын хууль баталснаар орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, бэлчээрийн ашиглалт, цөлжилт, худаг усны хангамж зэрэг асуудлыг бие даан шийдвэрлэх боломжийг олгосон. Аймгийн малын тоо толгойн албан татварыг тайлант онд 1,468.4 сая төгрөгөөр төлөвлөж, 1,352.9 сая төгрөг төвлөрч 115.5 сая төгрөгөөр орлого тасарсан байна.

Хүснэгт 7. Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая.төг)

№	Сумдын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	Хувь
1	Баацагаан	127.0	99.9	-27.1	78.7
2	Банябулаг	30.0	31.5	1.5	105.0
3	Баянговь	50.0	61.3	11.3	122.6
4	Баянлиг	103.5	105.0	1.5	101.4
5	Баян-Овоо	116.0	131.9	15.9	113.7
6	Баян-Өндөр	73.0	86.5	13.5	118.5
7	Баянхонгор	46.3	59.2	12.9	127.9
8	Баянцагаан	78.7	54.5	-24.2	69.3
9	Богд	86.5	87.2	0.7	100.8
10	Бөмбөгөр	151.5	58.2	-93.3	38.4
11	Бууцагаан	116.2	96.4	-19.8	83.0
12	Галуут	17.0	16.7	-0.3	98.2
13	Гурванбулаг	40.0	26.7	-13.3	66.8
14	Жаргалант	7.6	8.8	1.2	115.8
15	Жинст	100.0	104.8	4.8	104.8
16	Заг	-	11.8	11.8	
17	Өлзийт	102.4	102.9	0.5	100.5

18	Хүрээмарал	52.7	47.7	-5.0	90.5
19	Шинэжинст	80.0	81.3	1.3	101.6
20	Эрдэнэцогт	90.0	80.6	-9.4	89.6
Нийт		1,468.4	1,352.9	-115.5	92.1

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын газрын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө Баацагаан, Баянцагаан, Бөмбөгөр, Бууцагаан, Гурванбулаг, Хүрээмарал, Эрдэнэцогт сумдад удирдлага зохион байгуулалтын хангалтгүй ажилласнаас шалтгаалан 38.4-90.5 хувиар тасарсан байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 17/59 дүгээр хувь хүний орлогын албан татварын буцаан олголтод 1,000.0 сая төгрөг баталсныг Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн даргын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/15 дугаар тушаалд баталсан 1,049.9 сая төгрөгөөр олгохоор тооцож, аймгийн ИТХ-ын хуралдааны 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 21/06 дугаар тогтоолоор тус дүнгээр баталжээ.

2.1.2.Татварын бус орлого

Татварын бус орлогоор 2024 онд 66,913.0 сая төгрөгийн орлогыг оруулахаар баталснаас гүйцэтгэлээр 62,264.7 сая төгрөгийг бүрдүүлж, төлөвлөгөө 4,648.2 сая төгрөгөөр тасарчээ.

Хүснэгт 8. Татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая:төг)

Код	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Нийтлэг бус татварын орлого	11,153.5	7,292.2	-3,861.3	65.4
120002	Хүүгийн орлого	47.6	-	-	-
120003	Торгуулийн орлого	1,946.0	2,256.7	310.7	116.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,589.3	1,633.2	44.0	102.8
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	662.1	498.7	-163.4	75.3
1200044	Гадаадын эх үүсвэр	5,857.9	2,510.7	-3,347.3	42.8
120006	Газрын тосны орлого	42.4	-	-	-
120009	Бусад орлого	500.0	0.2	-499.8	0.0
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	508.2	392.6	-115.6	77.3
ТАТВАРЫН БУС ОРЛОГЫН ДҮН		66,913.0	62,264.7	-4,648.3	17.7

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төрийн аудитын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Татварын газар, Санхүүгийн хяналт дотоод аудитын алба, Цагдаагийн газруудаас тогтоосон торгуулийн орлогоор тайлант онд 1,946.0 сая төгрөг оруулахаас гүйцэтгэлээр 2,256.7 сая төгрөгийг оруулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогоор 508.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр уралдаан шалгаруулалтаар хувьчлагдсан барилга, байгууламж тоног төхөөрөмжийн гэрээний үнэ 253.6 сая, түрээсийн орлого 4.3 сая, нээлттэй дуудлага худалдааны орлогоос 134.7 сая нийт 392.6 сая төгрөгийг төсөвт оруулсан байна.

Аудитын илрүүлэлт:

➤ “Баянхонгор тохижил үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын хөрөнгөд бүртгэлтэй 2023 онд зам талбайн хавтан үйлдвэрлэлийн иж бүрэн тоног төхөөрөмжийг иргэн Н.Эрдэнэгэрэл хувьчилж тайлант онд орох гэрээний төлбөр 173.4 сая төгрөг төлөхөөс 30.0 сая төгрөг төвлөрүүлж 143.4 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна. Энэ нь Энэ нь “Зам талбайн хавтан үйлдвэрлэлийн барилга, байгууламж, иж бүрэн автомат тоног төхөөрөмжийг уралдаант шалгаруулалтаар хувьчлах гэрээ”-ний 2.2 дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд зээлийн төлбөрийн 143.4 сая төгрөг, гэрээний 5.2 дахь заалтын дагуу алдангийг тооцон иргэн Н.Эрдэнэгэрэлээр төвлөрүүлэх төлбөрийн актыг аймгийн ОНӨГ-т хүргүүлэв.

Үндсэн үйл ажиллагааны орлого

Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 2024 онд үндсэн үйл ажиллагааны орлогоор нийт 1,589.3 сая төгрөг оруулахаар төлөвлөснийг 44.0 сая төгрөгөөр давуулан биелүүлж, гүйцэтгэлээр 1,633.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн ба ХХС-аас 1,011.1 сая, ОНХС, бусад эх үүсвэрээс 622.2 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн орлогоор 1,589.3 сая төгрөгийг оруулахаар төлөвлөснөөс 1,011.1 сая төгрөгийг оруулж, орлогын төлөвлөгөө 578.2 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт 9. Хоршоо хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая.төг)

№	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	№	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
					11	Заг	27.0	31.4	116.3
1	Галуут	76.4	67.6	88.5	12	Баацагаан	93.0	45.6	49.0
2	Баян-Овоо	61.3	30.5	49.8	13	Бөмбөгөр	30.0	25.0	83.3
3	Эрдэнэцогт	8.0	16.8	210.0	14	Өлзийт	56.4	64.2	113.8
4	Бууцагаан	61.0	46.2	75.7	15	Хүрээмарал	164.6	32.5	19.7
5	Жинст	74.0	69.9	94.5	16	Баянбулаг	61.8	47.2	76.4
6	Богд	66.2	45.3	68.4	17	Шинэжинст	61.1	94.2	154.2
7	Баянлиг	35.0	50.9	145.4	18	Баянцагаан	89.6	55.4	61.8
8	Баянговь	50.0	51.6	103.2	19	Баян-Өндөр	76.4	36.9	48.3
9	Гурванбулаг	14.0	26.3	187.9	20	Баянхонгор	389.5	134.0	34.4
10	Жаргалант	94.0	39.6	42.1		ДҮН	1,589.3	1,011.1	63.6

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Сумдын хоршоо хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийхэд орлогын төлөвлөгөөг Хүрээмарал сум 19.7 хувь, Баянхонгор сум 34.4 хувь, Жаргалант сум 42.1 хувь, Баян-Өндөр сум 48.3 хувь, Баацагаан сум 49.0 хувь, Баян-Овоо сум 49.8 хувь, Баянцагаан сум 61.8 хувьтай биелүүлсэн нь хамгийн бага үзүүлэлттэй байгаа, төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 10 сумын 416.9 сая төгрөгийн 14 зөрчил илэрч 238.9 сая төгрөгийн 8 төлбөрийн акт, 178.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага өгсөн. Иймд аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч цаашид анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Туслах үйл ажиллагааны орлого

Туслах үйл ажиллагааны орлогоор 662.1 сая төгрөгийн орлого оруулахаар баталснаас гүйцэтгэлээр 533.7 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлж, 128.4 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний орлого

Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай” гэрээний загварын 2.1.3 дахь хэсэг, холбогдох хуулиудыг үндэслэн аймгийн Засаг дарга “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах,

үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай” гэрээг тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй харилцан тохиролцож уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг 7 аж ахуйн нэгжтэй “Орон нутгийн хамтын ажиллагааны” гэрээ байгуулсан байна.

Хандив тусламжийн орлогоор нийт 5,857.9 сая төгрөг оруулахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр Баянхонгор аймаг 1,635.4 сая, Галуут сум 30.2 сая, Бөмбөгөр сум 35.0 сая, Баян-Овоо сум 210.0 сая, Баян-Өндөр сум 300.0 сая, Шинэжинст сум 300.0 сая нийт 2,510.7 сая төгрөг төвлөрч 3,347.3 сая орлого дутуу төвлөрсөн байна.

Аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн төсөлд хандив тусламжийн орлогыг төлөвлөхгүй байх зөвлөмж өгсөн байхад хандивын орлогыг 5,857.9 сая төгрөг оруулахаар төлөвлөж (уул уурхайн компаниудаас орох “Орон нутгийн хамтын ажиллагааны” гэрээний орлого 2,690.0 сая төгрөг ба 3,167.9 сая төгрөгийн эх үүсвэр тодорхой бус) гүйцэтгэлээр 2,510.7 сая төгрөг орж орлогын төлөвлөгөө 3,347.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Иймд цаашид хандивыг төсвийн эх үүсвэрт батлахгүй байх зөвлөмжийг аймгийн Засаг дарга хүргүүлэв.

БҮЛЭГ 3 ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 54 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 54.5 ДАХЬ ЗААЛТЫН ДАГУУ, СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ҮР ДҮНГ ТООН БОЛОН ЧАНАРЫН ШАЛГУУРААР ТОДОРХОЙЛЖ, ЦААШДЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд харьяа 50 төсвийн байгууллага, 7 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 4 өрхийн эрүүл мэндийн төв, 41 тусгай сан, 20 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нийт 122 байгууллагын санхүүгийн тайлан, 110 боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын байгууллагуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал засварын зардал, аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө, замын сан, техник хяналт, барьцаа, аймгийн ОНХС-ийн данс нийт 5 дансны гүйлгээ нэгтгэгдсэн байна.

3.1.Хөтөлбөр арга хэмжээ, хүрэх үр дүн

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 17/57 дугаар “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” тогтоолын нэгдүгээр хавсралтаар аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийг баталсан байна.

Дээрх тогтоолоор 16 хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 108,785.8 сая төгрөгийг баталж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд сумдын ИТХ-аар тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх тоо болон чанарын үзүүлэлтийг тодорхойлсон байна.

Тайлант онд нийт баталсан төсвийг 16,956.8 мянган төгрөгөөр хэмнэж, 91,829.0 мянган төгрөгийг зарцуулсан ба аймгийн хэмжээнд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнг шалгуур үзүүлэлтээр нь дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 10. ТЕЗ, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт (сая.төг)

Хөтөлбөрийн		Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл
Нэр	Код			
Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	70105	Хурлын хуралдааныг улиралд 1-с доошгүй, удаа хуралдуулж шийдвэр гаргана.	5,520.0	5,275.6
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	70709	Аймгийн ГХУСАЗЗ-ийн ажлыг нэгдсэн төлөвлөгөөг баталж, гэмт хэргийн гаралтыг 5% бууруулна.	668.0	646.2

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	70106	Засаг даргын харьяа агентлаг, сумдын ЗДТГ-уудыг бодлого, удирдлагаар хангаж ИТХ-ын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах	42,070.1	39,312.0
		Бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх		
Замын сан	71101	Замын сангийн хөрөнгө оруулалтаар 16 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1,718.7	885.1
Хот байгуулалт тохижилт	71502	Баянхонгор аймгийн 365.0 мянган м2 нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ арчилгааг тогтмол хийж, халтиргаа гулгааг арилгаж, ногоон байгууламжийн арчилгаа, үйлчилгээг хийн, 25 мянган цэцэг тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлж иргэдийн цэвэр тавтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	1,880.2	1,876.6
Ойжуулалт	71403	500,000 мод ургуулж, арчилан зориудаар ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллгааг идэвхжүүлнэ.	314.4	313.8
Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	71413	Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж. Байгалт орчны чиглэлийн орон нутгийн байгууллагуудын салбар дундын зохицуулалтыг уялдуулж үйл ажиллаганы хэрэгжилтийг 90-ээс дээш хувьтай хэрэгжүүлнэ.	1,626.2	1,588.5
Нийгмийн халамж	71902	Баянхонгор аймгийн 650 иргэнд нийгмийн халамжийн үйлчилгээ, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмж, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлнэ.	157.1	131.9
Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	70503	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 35 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	32,528.8	22,216.2
		Сумын ОНХС-ын шилжүүлэх санхүүжилтийн дүнгээр		
Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	70426	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтын хяналтыг сайжруулах, бодлогоор удирдлагаар хангах, Орон нутгийн өмчийн дуудлага худалдаа зохион байгуулах	360.7	360.7
Мал аж ахуйг хөгжүүлэх	70801	20 сумын мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг аж ахуй нэгжид санхүүжилт олгож, малын эрүүл мэндийг хамгаалах вакцины авах	814.1	814.1
Ахмад настны хөгжил хамгаалал	72208	10 ахмад настанд асрамжийн үйлчилгээ үзүүлж, ахмадын хорооны үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.	397.8	356.4
Сургуулийн өмнөх боловсрол	71801	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулна.	2,538.3	2,488.4
Ерөнхий боловсрол	71802	Ерөнхий боловсролын байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулна.	7,980.0	7,878.7
Мэргэжлийн боловсрол	71804	Мэргэжлийн боловсролыг хүргэхэд шаардлагатай байрны ашиглалттай холбоотой тогтмол зардлыг бүрэн санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулна.	510.1	505.4
Соёл урлаг	71702	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулна.	2,028.5	1,968.3

Биеийн тамир спорт	71701	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулна.	2,024.9	1,930.5
Эмнэлгийн тусламж үйлчилгээ	71602	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж төрийн үйлчилгээг хэвийн явуулна.	2,769.9	2,734.6
Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	72101	Хоршоо хөгжүүлэх санд төлөвлөсөн хөнгөлөлттэй зээлийг олгоно.	2,877.8	547.1
		Зээлийн эргэн төлөлтийг бүрэн төвлөрүүлсэн байна.		
Нийт дүн			108,785.8	91,829.0

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2024 оны хөтөлбөр, хүрэх үр дүн

Аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгддэг байгууллагууд нь аймгийн Засаг даргатай 2024 оны үр дүнгийн гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтийг тайлагнан дүгнүүлсэн байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-аас 2024 онд Засгийн газрын чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд 19 сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг Төрийн аудитын газарт ирүүлсэн бөгөөд хэрэгжилтийн түвшин 72.7–100 хувь-тай байгааг тайлагнан, холбогдох сайдуудад хүргүүлсэн байна.

Аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг 78.5 хувьтай, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 91.6 хувьтай, Баянхонгор аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг 95.7 хувьтай тайлагнасан байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийг дараах байдлаар тайлагнасан байна.

- Аймгийн ИТХ-ын ээлжит болон ээлжит бус хуралдаан 8 удаа хуралдаж, 38 асуудлыг хэлэлцэн 36 тогтоолыг батлан хэрэгжүүлсэн байна.

- Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хуралдаанаар баталсан 2024 оны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилгын хүрээнд 84 заалт бүхий арга хэмжээг 256.4 сая төгрөг зарцуулан хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 84 арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэгжилтийг 97.1 хувьтай тайлагнасан байна.

- Замын сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 885.1 сая төгрөгөөр 15 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Дээрх төслүүдийг хэрэгжүүлснээр 950 метр хатуу хучилттай зам, 700 метр явган хүний замыг шинээр тавьж, шаардлагатай сургууль, цэцэрлэгийн орчмын авто замыг стандартын тэмдэг тэмдэглэгээтэй болгож, камержуулалтыг сайжруулах болон Баянхонгор сумын төв зам дагуух нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтын сайжруулсан байна.

- Баянхонгор сумын нийтийн эзэмшлийн 368,890 м2 талбайн цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж, 180 м2 явган замын засварлаж, 20,000 ширхэг 6 төрлийн нэг наст цэгийн үрсэлгээг хийж нийтийн эзэмшлийн талбайд шилжүүлэн тариалж, 920 м2 талбайд 230 ширхэг мод бут, 1100 м2 талбайд зүлэг тариалж ургуулсан байна.

- Төрийн өмчийн бүртгэлгүй 298 нэгж талбайн газрын зөрчлийг 123 нэгжээр, суурь үнэлгээ зөрүүтэй газрын зөрчлийг 44 нэгжээр, 50 тээврийн хэрэгслийн зөрчлийг 18 нэгжээр буулгасан, маргаантай 9 нэрийн хөрөнгө байгаагаас 1 хөрөнгийг балансаас балансад шилжүүлж 7 хөрөнгийг зөрчлийг арилгахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн, өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийн дагуу орон нутгийн өмчит 6 байгууллагын 238

нэрийн 464 ширхэг 323.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг 177.1 сая төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоож, дахин ашиглах зөвшөөрөл олгосон байна.

➤ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 100 төсөл, арга хэмжээг 12,107.2 сая, их засварын 37 төсөл, арга хэмжээг 3,046.5 сая төгрөгөөр бүрэн санхүүжүүлж, аймгийн хэмжээнд 68.3 хувьтай хэрэгжүүлсэн байна.

➤ Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 329 иргэнд 55.9 сая төгрөгийн үйлчилгээ үзүүлж, аймгийн хэмжээнд 55 иргэнд 66.0 сая төгрөгийг онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжийг олгож ажилласан.

➤ Аймгийн 20 сумын хувийн мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг 51 аж ахуй нэгжид 814.1 сая төгрөгийн санхүүжилт олгож, 13 нэр төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 1,621,590 тоо толгой малыг хамруулснаар халдварт өвчний гаралт өмнөх оноос 56.2 хувиар буурч, хэрэгжилт 98.2 хувьтай байна.

➤ Баянхонгор аймагт мэргэжлийн боловсрол, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, биеийн тамир, спорт, эрүүл мэнд болон соёлын байгууллагуудын цахилгаан, дулаан, цэвэр бохир усны зардлыг орон нутгийн төсвөөс бүрэн санхүүжүүлж, хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрэн хангасан байна.

СТА-аар Баянхонгор аймгийн 12 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу жилийн эцсийн тайланд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилт хүрэх үр дүн, хүрэх үр дүнгийн талаарх тоо болон чанарын шалгуур үзүүлэлтийг ирүүлээгүй байна.

Сумдын төсвийн төвлөрүүлэн захирагч нарын тайланд Төсвийн тухай хуулийн 54.5 заалтын дагуу хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилт, үр дүнгийн хэмжүүрийг тогтоож, хуулийн шаардлагыг биелүүлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

3.2.Батлагдсан төсөв

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 17/57 дугаар тогтоол, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор 2024 онд аймгийн төсвөөс зарцуулах зарлагыг нийт 101,382.0 сая төгрөгөөр, аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны 21/06 дугаар тогтоол, сумдын ИТХ-ын тогтоолоор анхны батлагдсан төсвийг 7,403.8 сая төгрөгөөр төсвийг нэмэгдүүлэн нийт зардлыг 108,785.8 сая төгрөгөөр төсвийг баталсан байна.

Хүснэгт 11. Аймаг, сумын ИТХ-аар баталсан 2024 оны нийт төсөв (сая.төг)

Үзүүлэлт	Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	101,382.0	108,785.8	7,403.8
УРСГАЛ ЗАРДАЛ	64,911.0	70,332.7	5,421.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,201.0	65,580.2	5,379.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,180.5	25,260.6	80.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,156.3	3,186.1	29.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,262.6	18,838.9	576.8
Хангамж, бараа материалын зардал	2,940.6	3,194.4	253.8
Нормативт зардал	64.8	82.8	18.0
Эд хогшил, урсгал засварын зардал	1,638.0	2,582.6	944.6
Томилолт, зочны зардал	363.9	485.8	121.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,911.1	3,162.5	251.4

Бараа үйлчилгээний бусад зардал	5,683.1	8,786.5	3,103.4
ТАТААС	60.0	60.0	0.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	60.0	60.0	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,650.1	4,692.4	42.3
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,734.7	1,853.7	119.0
Бусад урсгал шилжүүлэг	2,915.3	2,838.7	-76.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,266.4	35,267.7	2,001.3
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,895.9	2,877.8	-18.1
Хоршоо хөгжүүлэх сан	2,895.9	2,877.8	-18.1
Дамжуулан зээлийн төлбөр	307.6	307.6	0.0

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын 2023, 2024 оны тогтоол

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 576.8 сая, хангамж, бараа материалын зардлыг 253.8 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 944.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 251.7 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,103.4 сая, урсгал шилжүүлгийг 42.3 сая, хөрөнгийн зардлыг 2,001.3 сая төгрөгөөр нийт 7,173.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Төсөвт зохицуулалт хийх тухай” А/707 дугаар захирамжаар аймгийн ИТХ-аар баталсан төсөвт зохицуулалт хийсэн байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”, аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн “Аймгийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 21/06 дугаар тогтоолыг үндэслэн орон нутгийн төсөвт байгууллагуудын тайлант оны төсвийг 93.3 сая, сумдын төсөвт байгууллагуудын тайлант оны төсвийг 199.0 сая, нийт 292.4 сая төгрөгөөр хөтөлбөр хооронд шилжүүлэн зохицуулах байдлаар төсвийн тодотгол хийсэн байна.

3.3.Зардлын гүйцэтгэл

Аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд 108,785.8 сая төгрөгийн төсөв батлагдаж 91,829.2 сая төгрөг зарцуулснаас урсгал зардалд 66,570.0 сая, хөрөнгийн зардалд 25,259.3 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 12. Аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая.төг)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Б	3	4	5=3-4
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	108,785.8	91,829.2	16,956.6
УРСГАЛ ЗАРДАЛ	73,210.5	66,570.0	6,640.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68,457.7	63,266.6	5,191.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,266.7	24,202.1	1,064.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,186.1	2,981.5	204.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,838.9	18,533.3	305.6
Хангамж, бараа материалын зардал	3,215.1	3,128.2	86.9
Нормативт зардал	82.8	78.8	4.1
Эд хогшил, урсгал засварын зардал	2,582.6	2,375.5	207.1
Томилолт, зочны зардал	485.8	472.6	13.2

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,205.8	2,877.7	328.1
Бараа үйлчилгээний бусад зардал	11,593.9	8,617.0	2,976.9
ТАТААС	60.0	21.5	38.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,692.8	3,281.9	1,410.9
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,853.7	989.8	864.0
Бусад урсгал шилжүүлэг	2,839.0	2,292.1	546.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,575.3	25,259.3	10,316.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	928.0	930.0	-2.0
Удирдах ажилтан	222.0	223.0	-1.0
Гүйцэтгэх ажилтан	471.0	473.0	-2.0
Үйлчлэх ажилтан	140.0	140.0	0.0
Гэрээт ажилтан	95.0	94.0	1.0

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас харахад 108,785.8 сая төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 91,829.2 сая төгрөг зарцуулж, 16,956.6 сая төгрөгийг дутуу зарцуулсан ба ОНХС-ийн санхүүжилт 787.0 сая, хандивын орлого 3,347.3 сая төгрөгөөр тасарсантай холбоотойгоос гадна, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 1,064.7 сая, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 204.6 сая, байр ашиглалтад холбоотой тогтмол зардлыг 305.6 сая, хангамж, бараа материалын зардлыг 86.9 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,976.9 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 328.1 сая, хөрөнгийн зардлыг 10,316.0 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь голлох нөлөө үзүүлж байна. Тухайлбал.

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил 1,064.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь байгууллагын орон тооны хэмнэлтээс үүдэлтэй бөгөөд тухайн албан тушаалд төрийн албаны шалгалт өгсөн хүн тэнцдэггүй, зарим орон тоог хавсран, хослон гүйцэтгэсэнтэй холбоотой хэмнэлт үүссэн байна.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 305.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь халаалтын улиралд цаг агаар дулаан байсантай холбоотой зарим аж ахуйн нэгж халаалтаа оройтож өгсөнтэй холбоотой байна.
- Эд хогшил, урсгал засварын зардал 207.1 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Баянхонгор сумын ЗДТГ-ын захиалсан эд хогшил тухайн ирээгүй тул хэмнэлт гарсан, мөн Баян-Овоо сумын орлого тасарснаас эд хогшил урсгал засварын зардлыг санхүүжүүлээгүйтэй холбоотой байна
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 328.1 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Жаргалант сумын ИТХ, Өлзийт сумын ЗДТГ, Баянбулаг сумын ЗДТГ нь Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлуудыг тус эдийн засгийн ангилалд төлөвлөж хэмнэсэнтэй холбоотой байна.
- Бараа үйлчилгээний бусад зардал 2,976.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь байгалийн давагдашгүй хүчин зүйл бага гарснаас сумдын засаг даргын нөөц хөрөнгө, мөн байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Зарим зардлын хүрээнд

➢ Аймгийн ЗДТГ орон нутгийн телевиз, сайт, хэвлэл мэдээллийн 8 байгууллагатай нийт 32.0 сая төгрөгийн гэрээг байгуулж, зардлыг олгосон байна. Хамтран ажиллах гэрээнд аймгийн ИТХ болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаа, төр засгийн

бодлого шийдвэр, цаг үеийн онцлог үйл явдал, бүтээн байгуулалтын ажлын явц зэргийг орон нутгийн мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулахаар заажээ.

➤ Баянхонгор сумын 1, 2, 15 дугаар цэцэрлэгийн байрны хүрэлцээ болон Политехникийн коллежийн дотуур байрны ашиглалтын хугацаа дууссан зэрэг шалтгааны улмаас дээрх байгууллагууд түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж, 2024 онд орон нутгийн төсвөөс нийт 257.7 сая төгрөгийг түрээсийн зардалд баталж, гүйцэтгэлээр 255.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

➤ Баянхонгор аймгийн ЗДТГ-ын байр Монгол Ардын Намын байртай залгаа баригдсан байдаг бөгөөд тус намын байрыг хууль, хяналтын байгууллагаар намын өмч гэж тогтоосон тул тусдаа үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон байна. Үүний улмаас 225 м² талбай бүхий хэсгийг ЗДТГ түрээслэн ашиглаж, 2024 оны эхний гурван сарын түрээсийн төлбөр болох 15.3 сая төгрөгийг төсвөөс төлсөн боловч шүүхийн шийдвэрийн дагуу уг төлбөрийг цаашид төлөхгүй болсон байна.

➤ Аймгийн төрийн захиргааны байгууллагуудын хууль бус захиргааны шийдвэрээс үүдэн иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлэх шийдвэрийг гарган ажилладаг. Санхүүгийн тайлангийн 2022-2023 оны аудитын дүгнэлтээр Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн хүрээнд нийт 78.2 сая төгрөгийн 14 албан шаардлага, 2024 онд 180.6 сая төгрөгийн 3 албан шаардлага тус тус хүргүүлсэн байна.

➤ Баянхонгор аймгийн Засаг дарга "Ухаалаг засаглал" болон "Залаа зөвлөл" НҮТББ-тай гэрээ байгуулж, орон нутгийн төсвөөс нийт 35.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж, уг санхүүжилтийг бүрэн олгосон байна. Үүнд:

- *Ухаалаг засаглал* НҮТББ нь 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр "Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг хөгжүүлэх, ашиглалт, үйлчилгээний гэрээ" байгуулж, 15.0 сая төгрөгийн санхүүжилт авсан.
- *Залаа зөвлөл* НҮТББ нь "Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Залаа Жинстийн цагаан ямааны цөм сүргийг сайжруулах" төслийн хүрээнд гэрээ байгуулж, 20.0 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авсан байна.
- Аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/43 дугаар захирамжаар "Монголын Тэмээн соёл" улсын зөвлөгөөн, баяр наадамд 14.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн үр ашиггүй зарцуулалт

Баянхонгор аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 байгууллагад нийт 338.4 сая төгрөгийг зориулалт бус болон үр ашиггүй зарцуулалттай холбоотой 4 зөрчил илэрсэн байна. Үүнтэй холбогдуулан холбогдох байгууллагуудад албан шаардлага хүргүүлэн ажилласан. Үүнд:

- *Баацагаан сумын ЗДТГ нь гэрэл, цахилгааны зардлаас 1.5 сая төгрөгийг шилжүүлэн гэрлийн утас худалдан авсан нь зориулалтын бусаар зарцуулсан.*
- *Аймгийн ЗДТГ нь Засаг даргын 2024 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн А/120 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс 48.0 сая төгрөгийг автомашины сэлбэг, засварт зориулан зориулалтын бусаар зарцуулсан.*

- *Баянговь сумын ЗДТГ нь сумын ИТХ-ын тогтоолоор газрын төлбөрийн давсан орлогоос 75.0 сая төгрөгөөр автомашин худалдан авсан нь хууль, журмын хүрээнд нийцээгүй байна.*
- *Бууцагаан сумын ЗДТГ нь төрийн албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих зардлаар 6.2 сая төгрөгийн эм, тариа худалдан авахдаа 3.2 сая төгрөгийн хугацаа дуусах дөхсөн эм тариа худалдан авч, хугацаа дууссан шалтгаанаар устгаж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.*

3.3.1.Орон нутгийн хөгжлийн сан

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу улсын төсвөөс Баянхонгор аймагт олгох орлогын шилжүүлгийг нийт 21,576.9 сая төгрөг болгон баталсан. Үүнээс аймгийн ОНХС-д 7,631.2 сая төгрөг, сумдын ОНХС-д 13,945.7 сая төгрөг тус тус хуваарилагдсан байна.

Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 2024 онд хэрэгжүүлэх 657 төсөл, арга хэмжээнд нийт 32,527.8 сая төгрөгийн зардал батлагдсан бөгөөд дараах эх үүсвэрүүдээр санхүүжүүлэхээр баталсан. Үүнд:

- ✓ Улсын төсвийн шилжүүлэг – 21,576.9 сая төгрөг
- ✓ Малын тоо толгойн албан татвар – 1,468.4 сая төгрөг
- ✓ Хандив, тусламжийн орлого – 5,857.9 сая төгрөг
- ✓ Өмнөх оны үлдэгдэл – 2,210.2 сая төгрөг
- ✓ Бусад орлого – 533.3 сая төгрөг
- ✓ Орон нутгийн орлого – 881.1 сая төгрөг

Хандив тусламжийн орлогоор аймгийн ОНХС 4,300.0 сая, Баян-Овоо сум 583.0 сая, Шинэжинст сум 300.0 сая, Галуут сум 64.9 сая, Баян-Өндөр сум 600.0 сая, Бөмбөгөр сум 10.0 сая нийт 5,857.9 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр Баянхонгор аймаг 1,635.4 сая, Галуут сум 30.2 сая, Баян-Овоо сум 210.0 сая, Бөмбөгөр сум 35.0 сая, Баян-Өндөр сум 300.0 сая, Шинэжинст сум 300.0 сая нийт 2,510.6 сая төгрөг төвлөрч 3,347.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 17/57 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-ийн олгох орлогын шилжүүлгийг 7,264.7 сая, хандивын орлогыг 4,300.0 сая, орон нутгийн орлогыг 150.0 сая нийт 11,714.7 сая төгрөгөөр баталсан байна.

Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолоор ОНХС-ийн хөрөнгөөр 657 төсөл, арга хэмжээг 32,527.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 22,215.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Дээрх хөрөнгөөр өмнөх оноос шилжиж ирсэн 21 төсөл арга хэмжээ, тайлант онд шинээр эхлэх 79 төсөл арга хэмжээ, нийт 100 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 9,457.3 сая төгрөгийн зардал гарч, хандивын орлого тасарснаас шалтгаалж 21 төсөл арга хэмжээг хэрэгжээгүй байна.

Төсвийн шууд захирагчийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар сумдын ОНХС-д нийт 806.8 сая төгрөгийн 28 алдаа, зөрчил илэрснээс Баацагаан, Гурванбулаг сумдын санхүүгийн тайланд 7.4 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 32.6 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 690.6 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах 13 албан шаардлага, 76.2 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна.

Дээрх зөрчлөөс Баянхонгор сум 0.7 сая, Баянбулаг сум 0.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, Эрдэнэцогт, Баацагаан, Баян-Өндөр сумдын ОНХС-аас нийт 14.5 сая төгрөгийг зарцуулан "Малчдад зориулсан сургалт сурталчилгаа" ажлын хүрээнд иргэн Д.Болдбаатартай иргэдэд сургалт зохион байгуулахаар гэрээг байгуулсан атлаа сумын төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан байна.

Баянхонгор аймагт хөрөнгө оруулах 2021.05.31-ний өдрийн 2021/125 дугаар гэрээний дагуу "Наранмандал энтерпрайзэйс" ХХК-аас Баян-Овоо сумын ОНХС-д оруулах 205.0 сая төгрөгийн хандивын орлогыг төсвийн дансанд төвлөрүүлээгүй зарцуулсан зөрчлийг "Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө" гүйцэтгэлийн аудитаар авч үзэхээр шийдвэрлэсэн болно.

Баянхонгор аймгийн болон 20 сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, хяналтыг МУЕА-ын баталсан аудитын төлөвлөгөөний дагуу "Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө" гүйцэтгэлийн аудитаар шалгаж байна.

3.3.2.Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал

Аймгийн 2024 оны хөгжлийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг 1,896.4 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 57 төсөл арга хэмжээнд 1,783.0 сая төгрөгийг зарцуулж 105.5 сая төгрөгийн хэмнэсэн байна.

Нийт 57 төсөл арга хэмжээнээс 8.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. Үүнд:

- Гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой мэдээллийг төлбөртэй авах арга хэмжээг зохион байгуулах,
- Төсвийн ил тод байдлыг хангах, иргэдийг мэдээллээр хангах зорилгоор "Иргэдийн төсөв" Баянхонгор товхимол боловсруулан олон нийтэд хүргэх

3.3.3.Их засвар

Аймгийн ИТХ-ын тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтын хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засварын ажилд нийт 35 төсөл, арга хэмжээг 3,046.5 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр баталсныг 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн "Баянхонгор аймгийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" 21/06 дугаар тогтоолоор нийт 37 төсөл, арга хэмжээнд 3,046.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тодотгон баталсан байна.

Гүйцэтгэлээр баталсан 37 их засварын төсөл, арга хэмжээнээс 30 төсөл, арга хэмжээ хэрэгжиж, 3,044.1 сая төгрөгийн зарцуулалт хийгдсэн бөгөөд 7 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна. Үүнд:

- Баянбулаг сумын спорт цогцолбор, цэцэрлэгт хүрээлэнгийн ажил 44.5 сая,
- Баянхонгор сумын 6 дугаар байрын 30 айлын засварын ажил 51.0 сая,
- Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн гадна бохир усны шугам сүлжээний ажил 22.0 сая,
- Бөмбөгөр сумын спорт заалны засварын ажил 40.0 сая,
- Хүрээмарал сумын цэцэрлэгийн барилгын засварын ажил 65.0 сая,
- Заг сумын Засаг даргын тамгын газрын дээврийн засварын ажил 20.0 сая,
- Баянхонгор сумын 314, 316 дугаар байрны дээврийн засварын ажил 5.0 сая,

Аудитын илрүүлэлт:

Аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн "Хөрөнгийн зохицуулалт хийх тухай" А/720 дугаар захирамжаар Баянхонгор сумын 12 дугаар цэцэрлэгийн их засварын ажлыг 239.6 сая төгрөг, Богд сумын цэцэрлэгийн барилгын засварын ажлыг 78.0 сая төгрөг, Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацийн барилгын засварын ажлыг 38.7 сая төгрөгөөр нийт 356.3 сая

төгрөгөөр аймгийн ИТХ-аар баталсан төсвийн дүнгээс нэмэгдүүлэн зохицуулалт хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай 42 дугаар зүйлийн 42.7 дахь “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгаагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно”, 45 дүгээр зүйлийн 45.2 дахь “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.2 дахь “Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл” гэсэн заалтуудыг зөрчсөн тул аймгийн Засаг даргад зөрчил давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.3.4.Техник хяналт, барьцаа хөрөнгө оруулалт

Төрийн сан дахь 100030051350 тоот Барьцаа хөрөнгө оруулалт дансны мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 2,542.2 сая төгрөг, тайлант хугацаанд 7,126.9 сая төгрөгийн орлого төвлөрч, 1,341.8 сая төгрөгийн зарцуулалт гарч, оны эцсийн үлдэгдэл 8,327.3 сая төгрөг байна.

Барьцаа хөрөнгийн дансанд УТХО, аймгийн ОНХС, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 49 төсөл арга хэмжээний 7,126.9 сая төгрөг төвлөрч 1,341.8 сая төгрөгийн зарлага гарсан ба үүнээс 7 төсөл арга хэмжээний 709.7 сая төгрөгийн барьцааг чөлөөлж буцаан шилжүүлж, 4 төсөл, арга хэмжээнд 448.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, өмнөх оны аудитын актын төлбөрт 40.0 сая төгрөг төлсөн.

Аудитын илрүүлэлт:

- Барьцаа данснаас аймгийн ЗДТГ-ын албаны хэрэгцээнд худалдан авсан Land Cruiser 200 жийп автомашины барьцаа 9.9 сая төгрөгийг гэрээнд заасан хугацаанаас нь өмнө аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/399 дугаар захирамжаар чөлөөлсөн байна. Энэ нь 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 2024/69 дугаар гэрээний 5.3 дахь заалтыг зөрчсөн тул гэрээний үүргийг хэрэгжүүлэн барьцааны мөнгийг буцаан төвлөрүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Хүснэгт 13. Барьцаа хөрөнгө оруулалтын дансны орлого, зарлагын гүйлгээ (сая.төг)

№	Хөрөнгө оруулалтын ажлын нэр	Байршуулсан дүн	Үүнээс: Чанарын баталгаа	Барьцаа чөлөөлсөн
1	УТХО-аар хэрэгжсэн ТАХ	6,896.1	82.5	600.8
2	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ	230.8	61.1	108.9
НИЙТ ОРЛОГЫН ДҮН		7,126.9	143.6	709.7

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төрийн сан дахь 100030051370 тоот Бх.Техник хяналт зардлын дансны эхний үлдэгдэл 693.4 сая төгрөг, УТХО-аас 777.1 сая төгрөг, ОНХС-аас 95.4 сая төгрөг, сум дундын ойн ангиас 245.0 сая төгрөг, барьцаа данснаас 23.1 сая төгрөг, техник хяналтын данснаас 2.9 сая төгрөг, иргэн аж ахуй нэгжээс 5.0 сая төгрөг, данс хоорондын зардал хаасан 519.4 сая төгрөг, нийт 1,668.0 сая төгрөгийн орлого төвлөрснийг дараах хөтөлбөр, арга хэмжээнд нийт 1,657.2 сая төгрөгийг зарцуулж, 704.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 14. Бх.Техник хяналтын зарлагын гүйлгээ (сая.төг)

Д/д	Зардлын төрөл	Дүн
1	Өвс тэжээл татан авахад	245.0
2	Сургалт зөвлөгөөн, томилолтын зардал	28.7
3	Тоног төхөөрөмж худалдан авах	69.1
4	110/35/6 кв дэд станцын захиалагчийн хяналтын зардал	179.0
5	ГХБХБГ-т санхүүжилтэд	86.1
6	Аймгийн орлогод	500.0
7	Техник хяналтын зардал	29.9
8	Данс хоорондын шилжүүлэг	519.4
НИЙТ ДҮН		1,657.2

Эх сурвалж: Техник хяналтын зардлын дансны хуулга

Орон нутгийн 2023-2024 оны өвөлжилт хаваржилт нь зудын эрсдэл нүүрлэсэнд аймгийн онцгой комиссын шийдвэрээр техник хяналтын зардлаас 245.0 сая төгрөгөөр өвс тэжээл татан авч сумуудад хөнгөлөлттэй үнээр зарж өвөлжилт хаваржилтыг малчин ард иргэд хохирол багатай даван туулсан байна. Өвс тэжээлд зарцуулсан 245.0 сая төгрөгийг буцаан бүрэн байршуулсан байна.

Техник хяналтын зардлын дансны хяналтын зардалд 208.9 сая төгрөг зарцуулсан ба нийт зардлын 7 хувийг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

➤ *Техник хяналтаас зардлаас аймгийн Засаг даргын 2024 оны А/281 дугаар захирамжаар 5.1 сая, 2024 оны А/685 дугаар захирамжаар 16.6 сая төгрөгийн шаардлагатай тоног төхөөрөмжүүд аймгийн ЗДТГ худалдан авсан боловч орлого авч бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтыг зөрчсөн тул тоног төхөөрөмжийг орлого авч бүртгэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.*

➤ *Техник хяналтын зардлаас аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 17/57 дугаар тогтоолоор Бусад эх үүсвэрийн орлогоор 500.0 сая төгрөг баталж 2024.09.27-нд 150.0 сая, 2024.12.11-нд 350.0 сая нийт 500.0 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд шилжүүлж зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан барилгын ажлын захиалагчийн дүрмийн 2.7 дахь “Захиалагчийн санхүүжилтийн эх үүсвэр нь барилга байгууламжийн төсөвт өртөгт тусгагдсан байх бөгөөд зардлыг зориулалтын дагуу ашиглана” гэсэн заалтыг зөрчсөн тул аймгийн Засаг даргад зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.*

3.3.5.Замын сан

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн XVII хуралдааны 17/57 дугаар тогтоолоор АТБӨЯХАТ-ыг 650.0 сая, орон нутгийн авто зам ашигласны төлбөр 340.0 сая, торгуулийн орлого 649.7 сая, нийт 1,639.7 сая төгрөгөөр баталж, аймгийн ИТХ-ын хуралдааны 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн XXI хуралдааны 21/06 тогтоолоор өмнөх оны үлдэгдэл 79.0 сая төгрөгийг нэмж тодотгон 2024 онд шинээр хэрэгжүүлэх 16 төсөл, арга хэмжээнд 1,718.7 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

Замын сангийн харилцах дансанд оны эхэнд 39.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвараар 727.3 сая, авто зам ашиглалтын хураамж 359.8 сая, торгуулийн орлого 396.7 сая нийт 1,483.8 сая төгрөгийн санхүүжилт авч 15 төсөл арга хэмжээнд 885.1 сая төгрөгийн зардал гаргаж 637.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд 649.5 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж 10 төсөл арга хэмжээний 235.5 сая төгрөгийн гэрээ байгуулж, 794.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээнд 2 удаа нээлттэй тендер зарлаж оролцогч ороогүй байна.

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн баруун урд уулзвараас Арван мянгатын бетон зам хүртэлх 1 км авто зам тавих ажил нь хэрэгжээгүй байна.

3.3.6.Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал

Аймгийн татварын орлогоор 3,821.6 сая төгрөгийн орлого төвлөрч, Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 17/57 дугаар тогтоол, Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 21/06 дугаар тогтоолоор үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрт 640.0 сая төгрөг баталж Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т Ус рашааны нөөц

ашигласны төлбөрийн 35 хувиас доошгүй төлбөрийг байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 227.5 сая төгрөг баталж 10 арга хэмжээнд 210.7 сая төгрөгийг зарцуулж 16.8 сая төгрөгийг орон нутгийн буцаан төвлөрүүлсэн байна.

Тухайн онд хэрэгжих 227.5 сая төгрөгийн өртөгтэй 10 төсөл арга хэмжээнээс 3 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж 154.2 сая төгрөгийн гэрээг байгуулсан байна

Сумдад байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагааны зардалд 576.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.3.7.Хоршоо хөгжүүлэх сан

Сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эхэнд 1,384.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлан онд зээлийн эргэн төлөлтөөр 1,575.0 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 931.9 сая төгрөгийг төвлөрүүлж 467.8 сая төгрөгийн зарцуулж оны эцэст 1,848.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 15. Сумын хоршоо хөгжүүлэх мөнгөн хөрөнгийн судалгаа (сая.төг)

Д/д	Сумын нэр	Эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл	Д/д	Сумын нэр	Эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл
1	Баацагаан	66.5	111.7	11	Бууцагаан	25.3	71.5
2	Баянбулаг	63.1	110.0	12	Галуут	28.7	90.6
3	Баянговь	46.2	93.1	13	Гурванбулаг	131.4	156.7
4	Баянлиг	113.2	163.9	14	Жаргалант	67.3	36.3
5	Баян-Овоо	90.5	120.8	15	Жинст	58.3	128.1
6	Баян-Өндөр	21.3	58.0	16	Заг	65.2	46.5
7	Баянхонгор	161.7	129.0	17	Өлзийт	124.2	94.4
8	Баянцагаан	64.4	119.2	18	Хүрээмарал	4.0	36.3
9	Богд	100.5	64.1	19	Шинэжинст	54.0	118.1
10	Бөмбөгөр	57.2	42.3	20	Эрдэнэцогт	41.3	57.8
Нийт дүн						1,384.3	1,848.4

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант онд хоршоо хөгжүүлэх сангаас 1,575.0 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөж гүйцэтгэлээр 547.1 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна.

Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн авлага 2024 оны эхний үлдэгдэл 3,913.6 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 3,536.6 сая төгрөг болж 377.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 16. Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэл

№	Сумын нэр	Хувь хүмүүст олгосон зээлийн авлага		№	Сумын нэр	Хувь хүмүүст олгосон зээлийн авлага	
		Өмнөх он	Тайлант он			Өмнөх он	Тайлант он
1	Баянбулаг	157.7	111.1	11	Баян-Өндөр	180.0	143.1
2	Баянговь	167.7	116.1	12	Галуут	248.9	181.4
3	Богд	112.4	151.7	13	Гурванбулаг	72.5	46.3
4	Баянлиг	144.7	96.9	14	Жаргалант	181.7	212.1
5	Баян-Овоо	81.4	50.9	15	Жинст	134.6	71.9
6	Бөмбөгөр	130.3	144.7	16	Заг	133.7	149.7
7	Бууцагаан	215.5	192.3	17	Хүрээмарал	209.9	177.3
8	Баянхонгор	912.4	1,031.6	18	Шинэжинст	156.0	61.7
9	Баацагаан	191.8	150.6	19	Эрдэнэцогт	146.5	132.1
10	Баянцагаан	203.2	147.8	20	Өлзийт	132.7	167.4
НИЙТ ДҮН						3,913.6	3,536.6

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Энэ нь тайлант онд нийт 13 төсөл арга хэмжээнд 528.7 сая төгрөгийн зээл олгож, 1,011.8 сая төгрөгийн зээлийн төлбөрийг төлүүлсэнтэй холбоотой ба энэ хэмжээгээр СХС-ийн мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,848.4 сая төгрөг болж өмнөх оноос 377.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэл Баянхонгор сум хамгийн өндөр буюу 1,031.6 сая, Гурванбулаг сум хамгийн бага буюу 46.3 сая төгрөгийн авлагатай байна.

Хүснэгт 17. Сумын хоршоо хөгжүүлэх зарлагын судалгаа (сая.төг)

Д/д	Сумын нэр	зарлага		Д/д	Сумын нэр	зарлага	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл			Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Баацагаан	153.0	0.4	11	Бууцагаан	61.0	0.0
2	Баянбулаг	58.6	0.4	12	Галуут	27.6	5.6
3	Баянговь	46.2	4.7	13	Гурванбулаг	145.4	1.0
4	Баянлиг	35.0	0.15	14	Жаргалант	50.0	70.5
5	Баян-Овоо	61.3	0.15	15	Жинст	52.8	0.15
6	Баян-Өндөр	21.3	0.15	16	Заг	63.0	50.1
7	Баянхонгор	160.0	166.7	17	Өлзийт	119.6	94.1
8	Баянцагаан	150.6	0.6	18	Хүрээмарал	164.6	0.15
9	Богд	74.3	81.6	19	Шинэжинст	52.8	30.1
10	Бөмбөгөр	30.0	39.9	20	Эрдэнэцогт	48.0	0.4
Дүн						1,575.0	547.1

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 онд Хоршоо хөгжүүлэх сангаас 1,575.0 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн боловч 528.7 сая төгрөгийн зээл л олгогджээ. Үүний хүрээнд 13 сум огт хөнгөлөлттэй зээлийг олгоогүй байна.

Энэ нь 2023-2024 онд сумын Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авах шалгуур хангасан хоршооны тоо буурсан, Шинэ хөдөө төсөл хэрэгжсэнтэй холбогдуулан хоршооны гишүүд арилжааны банкнаас бага хүүтэй зээлд хамрагдсантай холбоотой байна.

Цаашид ХХС-аас зээл олгох журамд өөрчлөлт оруулах замаар орон нутагт шинээр үйлдвэрлэл бий болгох, жижиг дунд үйлдвэрлэлийг өргөжүүлж, иргэдийн амьдралд бодит орлогыг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлэх саналыг Үндэсний аудитын газарт уламжлав.

Сумдын хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 416.9 сая төгрөгийн 14 зөрчил илэрч 238.9 сая төгрөгийн 8 төлбөрийн акт, 178.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага хүргүүлсэн байна.

БҮЛЭГ 4 ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛИЙН СУДАЛГАА

Төрийн аудитын байгууллагаас 2024-2025 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл"-д ерөнхий зүйл, тайлант хугацаанд хийх аудитын явцад анхаарах асуудал, баримтлах ерөнхий чиглэлийн санхүүгийн тайлангийн аудитаар горим сорилыг хэрэгжүүлэн холбогдох судалгааг нэгтгэсэн.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар ерөнхий чиглэлийн хүрээнд худалдан авах ажиллагаа, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж (210801), бараа үйлчилгээний бусад зардал (210901), орон тооны судалгаанд Засаг даргын харьяаны төсөвт 51, орон нутгийн өмчит 11 нийт 62 байгууллагын судалгааг нэгтгэсэн.

Улсын төсвөөс санхүүждэг 138 байгууллагын ерөнхий чиглэлийн судалгааг 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр УАГ-ын Санхүү-нийцлийн аудитын газарт албан мэйлээр хүргүүлсэн.

1. Худалдан авах ажиллагааны судалгаа

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудаас авсан худалдан авах ажиллагааны судалгааг 2 чиглэлээр ангилан дүгнэлт өглөө. Үүнд:

1. Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан худалдан авах ажиллагаа

2. Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд болон ОНӨААТҮГ-уудын худалдан авах ажиллагаа

1.1. Баянхонгор аймгийн худалдан авах ажиллагааны газар нь ОНХС-ийн хөрөнгө оруулалт болон Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтыг зохион байгуулсан байна. Тухайлбал, Баянхонгор аймгийн Баянхонгор сумын ус хангамжийн эх үүсвэрийг хашаажуулах, Шинэ суурьшлын бүсийн үерийн далангийн ажил, "Эрдэнэмандал" хайрхны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажил, Аймгийн ЗДТГ-ын шатах, тослох материал, бичиг хэргийн материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах, Сумдын сургууль, цэцэрлэг, спорт заалнуудын их засварын ажил, сумдын ундны эх үүсвэрийн усан сан байгуулах ажил, сумын цэцэрлэгийн тоглоомын талбай байгуулах, сургуулийн гал тогооны их засвар, эрүүл мэндийн төвийн шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил нийлүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх аж ахуй нэгж байгууллагыг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулсан байна.

Тайлант онд Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газраас нийт 13,961.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 49 тендер шалгаруулалт зарлаж ажилласан байна. Үүнд, ОНХС-ийн хөрөнгөөр 7,277.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий нийт 20 бараа, ажил үйлчилгээ худалдан авах, Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 6,684.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 28 бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар 29 тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 20 тендерийг харьцуулалтын аргаар тус тус зарлаж ажилласан байна. Тус тендерүүд дотроос 365.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих 2 тендер шалгаруулалтад оролцогч этгээд материал ирүүлээгүй тул үр дүн гараагүй байна.

Хүснэгт 18. Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын зохион байгуулсан тендер

Д/д	Байгууллагын нэр	Эх үүсвэр	Төлөвлөгөөний ангилал	Тоо	Тендер шалгаруулалтын арга		Төсөвт өртөг
					НТШ	Харьцуулалт	
1	Баянхонгор аймгийн худалдан авах ажиллагааны газар	ОНХС	Бараа	3	2	1	570.0
			Ажил	17	9	8	6,707.3
		Орон нутгийн төсөв	Бараа	5	2	3	834.1
			Ажил	24	16	8	5,849.9
Дүн				49	29	20	13,961.3

Эх сурвалж: Ерөнхий чиглэлийн судалгаа

Тус газраас зохион байгуулсан тендер шалгаруулалттай холбоотойгоор нийт 60.9 сая төгрөгийн тендерийн баталгаа, 171.2 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгаа байршсан байна.

Худалдан авах ажиллагааны газар зарлагдсан тендерүүдээс зарим нь эрх шилжих гэрээгээр холбогдох байгууллагуудруу шилжин бараа, ажил үйлчилгээгээ худалдан авах ажиллагаагаа явуулсан байна.

1.2. Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн харьяа сумын ЗДТГ-ын 10 байгууллага түлш шатахуун, өвс тэжээл, ус болон хог тээврийн автомашин, хяналтын камер худалдан авахаар, орон нутгийн өмчит 2 байгууллага нь түлш шатахуун болон өөрийн үйл ажиллагаанд хамаарах хөрөнгүүдийг худалдан авахаар нийт 1,619.4 сая төгрөгийн 23 бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулсан байна.

Хүснэгт 19. Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө

Д/д	Байгууллагын нэр	Тоо	Ангилал		Тендер шалгаруулалтын арга	
			Бараа	Ажил	Нээлттэй тендер шалгаруулалт	Харьцуулалтын арга
1	Төсөвт байгууллага	10	13	2	4	11
2	Орон нутгийн өмчит байгууллага	2	9	-	4	5
дүн		12	21	2	8	16

Эх сурвалж: Ерөнхий чиглэлийн судалгаа

Аймгийн засаг даргын харьяа байгууллагын 23 тендерээс 1,576.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 тендер дээр 1,469.6 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан байна. Гэрээний санхүүжилтэд 1,324.8 сая төгрөгийг олгож, 65.8 сая төгрөгийн 1 гэрээний хугацаа дуусаагүй, 5 гэрээнээс нийт 5.8 сая төгрөгийн санхүүжилт хэмнэгдсэн байна.

Хүснэгт 20. Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Байгууллагын нэр	Ангилал	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Гүйцэтгэл	Гэрээ гүйцэтгэлийн зөрүү	
						хэмнэлт	Тайлбар
1	Төсөвт байгууллага	Бараа	483.1	470.8	466.4	4.4	4 гэрээнээс
		Ажил	133.2	133.1	58.5	1.4	73.2 сая төгрөгийн санхүүжилт нь төслөөс хийгдсэн
2	Орон нутгийн өмчит байгууллага	Бараа	959.9	865.7	799.9	-	1 гэрээний хугацаа дуусаагүй
Дүн			1,576.2	1,469.6	1,324.8	5.8	

Эх сурвалж: Ерөнхий чиглэлийн судалгаа

Өлзийт сумын ЗДТГ-ын 43.2 сая төгрөгийн шатах, тослох материал худалдан авах тендер шалгаруулалтад оролцогч материал ирүүлээгүй тул шууд гэрээгээр худалдан авалтыг хийсэн байна.

Тендер шалгаруулалтыг зохион байгуулахдаа шатах тослох материал худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар, үндсэн хөрөнгө худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан байна.

Сумын төсөвт байгууллага дээр зарлагдаж буй тендер шалгаруулалтын үнэлгээний хороог байгуулахад худалдан авах ажиллагааны АЗ сертификаттай хүн цөөн байгаагаас шалтгаалан хараат бус гишүүн олддоггүй сул талтай байна.

Баянхонгор аймгийн Эрчим хүч цахилгаан түгээх компани нь 100.0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий хөрөнгө худалдан авах 2 тендер шалгаруулалтын ажил дээр тендерийн баталгаа байршуулсан бөгөөд гүйцэтгэлийн баталгаа шаардаагүй байна.

Дээрх худалдан авах ажиллагаатай холбоотойгоор 876.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 448.1 сая төгрөгийн бараа материал нийт 1,324.8 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж тайлагнасан байна.

СТА-аар Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад худалдан авах ажиллагаатай холбоотойгоор 1090.8 сая төгрөгийн 5 зөрчил илэрч, 339.3 сая төгрөгийн 3 албан шаардлага, зөрчлийг арилгах 751.5 сая төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнд:

- Галуут сумын ЗДТГ нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас иргэн Б.Алтансүхтэй Өхэгийн рашааны булгийн эх хаших ажлыг 29.0 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн тул зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлсэн.

- Баацагаан сумын ЗДТГ нь байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2024 оны 06 сард "Баацагаан сумын Зүүн хаяа, багийн хөөвөр, Баянбулаг багийн хөтөл шандын эхийг хамгаалах хайс хашаа" худалдан авах 20.0 сая, булаг шандын эхийг хамгаалах хашаа хатгах 10.0 сая, нойл хийхэд 6.0 сая, хогийн сав авахад 2.0 сая нийт 38.0 сая төгрөгийн гэрээг иргэн Б.Жаргалтай 2 удаагийн байгуулан шилжүүлсэн тул зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлж ажилласан.
- "Чандмань-Баянхонгор" ХК нь ус хангамжийн өргөх насос станцын ажлын зураг төсөл боловсруулах нийт 33.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу тендер зарлаагүй "Инж байгууламж ХХК"-тай шууд гэрээ байгуулан хийлгүүлсэн тул зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлсэн.
- Баянхонгор "Цэвэр хот" ОНӨААТҮГ нь тайланд онд 276.6 сая төгрөгийн шатах тослох материал худалдан авахдаа худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр шууд худалдан авалт хийсэн тул зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлсэн.
- Баянхонгор сумын ӨЭМТ-үүд нь тайлант онд 713.5 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахдаа худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүй шууд худалдан авалт хийсэн тул зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлж ажилласан.

2. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж (210801)

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 2024 онд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж (210801)-ийн зардалд 3,060.5 сая төгрөг баталж гүйцэтгэлээр 2,752.5 сая төгрөгийг зарцуулж 308.0 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Зардлын гүйцэтгэлийг ангилан авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 21. Зардлын ангиллаар

(сая төгрөг)

№	Хөтөлбөр	Зардлын ангилал	Дүн	Нийт зардлын дүнд эзлэх хувь
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,075.4	39.1
2	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	8.6	0.3
3	80106	Баг, хорооны ҮАЗардал	1.1	0.0
4	80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	84.2	3.1
5	80219	Харуул, хамгаалалтын зардал	9.1	0.3
6	80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүд	30.0	1.1
7	81701	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	874.9	31.8
8	82201	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	26.9	1.0
9	82212	Хур хог хаягдал, орчны бохирдол	35.2	1.3
10	82502	Мал эмнэлгийн үйлчилгээ	599.0	21.8
11	82611	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	7.9	0.3
НИЙТ			2,752.5	100.0

Эх сурвалж: Ерөнхий чиглэлийн судалгаа

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлын 39.8 хувийг үндсэн үйл ажиллагааны зардалд, 31.8 хувийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд, 21.8 хувийг мал эмнэлгийн үйлчилгээнд, 7.3 хувийг бусад зардал зарцуулсан байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлын зарцуулалтад СТА-аар 10 байгууллагад 248.4 сая төгрөгийн 13 зөрчил илэрч, 3.1

сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 207.2 сая төгрөгийн 10 албан шаардлага, зөрчлийг арилгах 38.0 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнд:

- Заг сумын ИТХ анхан шатны баримтгүйгээр ажлын хөлсөнд 0.2 сая, Галуут сумын ЗДТГ иргэн Б.Алтансүхтэй Өхээгийн рашааны булгийн эх хаших ажлын гэрээг 29.0 сая төгрөгөөр байгуулж 2.9 сая төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцоогүй тул төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.
- Заг сумын ИТХ-ын даргын 2024 оны А/10 дугаар захирамжаар ИТХ-ын төлөөлөгч нарт тойрогтоо ажиллах үйл ажиллагааны зардалд 14.0 сая төгрөгийг шилжүүлсэн ба зарцуулалтын тайлан холбогдох анхан шатны баримт байхгүйд албан шаардлага хүргүүлсэн.
- Санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгаж тайлагнаагүй байхад Эрдэнэцогт сумын ЗДТГ 3.4 сая, Баян-Өндөр сумын ЗДТГ 2.6 сая, Баянлиг сумын ЗДТГ 4.0 сая, Баянговь сумын ЗДТГ 4.0 сая, Өлзийт сумын ЗДТГ 2.5 сая, Хүрээмарал сумын ЗДТГ 2.1 сая, нийт 18.5 сая төгрөгийг зарцуулсанд албан шаардлага хүргүүлсэн.
- Баян-Овоо сумын ЗДТГ нь суурьшлын бүсийн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны төлбөр 16.5 сая төгрөгийг шилжүүлэхдээ Е-нэхэмжлэлгүй гүйлгээг хийсэн, Баянхонгор аймаг дахь Сум Дундын Иргэний Хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны шүүгчийн захирамжаар 177.0 сая төгрөгийг хариуцагч Ж.Хатанбаатар, Засаг даргын тамгын газраар төлүүлэхээр шийдвэр гарч тайлант онд Засаг даргын тамгын газар нь 152.2 сая төгрөгийг ШШГГ-ын 230000037952 тоот дансанд төлсөнд албан шаардлага хүргүүлсэн.
- Баянцагаан сумын ЗДТГ нь байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2024 оны 06 сард "Баацагаан сумын Зүүн хаяа, багийн хөөвөр, Баянбулаг багийн хөтөл шандын эхийг хамгаалах хайс хашаа" худалдан авах 20.0 сая, булаг шандын эхийг хамгаалах хашаа хатгах 10.0 сая, нойл хийхэд 6.0 сая, хогийн сав авахад 2.0 сая нийт 38.0 сая төгрөгийн гэрээг иргэнтэй 2 удаа байгуулан шилжүүлсэнд зөвлөмж хүргүүлсэн.

Мөн бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжаас уралдаан тэмцээний зардал болон бэлэг дурсгалын зүйл худалдан авсан зөрчлүүд илэрснийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу салган авч үзсэн болно.

3. Бараа үйлчилгээний бусад зардал (210901)

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 2024 онд бараа үйлчилгээний бусад зардал (210901)-д 11,355.1 сая төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 8,370.0 сая төгрөгийг зарцуулж 2,965.1 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Зардлын гүйцэтгэлийг ангилан авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 22. Зардлын ангиллаар

(сая төгрөг)

№	Хөтөлбөр	Зардлын ангилал	Дүн	Нийт зардлын дүнд эзлэх хувь
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	509.3	6.1
2	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	348.0	4.2
3	80106	Баг, хорооны ҮАЗардал	4.5	0.1
4	81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	3,606.4	43.1
5	81104	Бусад ангилагдаагүй нөөц хөрөнгө	1,783.0	21.3

6	81549	Ахмадын сан	2.0	0.0
7	81701	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	787.6	9.4
8	82201	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	294.0	3.5
9	82310	Гамшгаас сэргийлэх сургалт сурталчилгаа	281.7	3.4
10	82502	Мал эмнэлгийн үйлчилгээ	215.1	2.6
11	82611	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	538.4	6.4
НИЙТ			8,370.0	100.0

Эх сурвалж: Ерөнхий чиглэлийн судалгаа

Бараа үйлчилгээний бусад зардлын 6.1 хувийг үндсэн үйл ажиллагааны зардалд, 43.1 хувийг Засаг даргын нөөц хөрөнгөд, 3.4 хувийг гамшгаас сэргийлэх сургалт сурталчилгааны зардалд, 9.4 хувийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд, 2.6 хувийг мал эмнэлгийн үйлчилгээнд, 3.5 хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд, 21.3 хувийг бусад ангилагдаагүй нөөц хөрөнгөд, 4.2 хувийг гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээнд, 6.4 хувийг жижиг дунд үйлдвэрийг дэмжихэд тус тус зарцуулсан байна.

Бараа үйлчилгээний бусад зардлын зарцуулалтад СТА-аар 95.8 сая төгрөгийн 9 зөрчил илэрч, 3.6 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 26.5 сая төгрөгийн 5 албан шаардлага, зөрчлийг арилгах 66.0 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнд:

- Шинэжинст сумын ЗДТГ нь Засаг даргын нөөц хөрөнгөөс багш, эмч нарт 46.5 сая төгрөгийн тэтгэмж олгохдоо 4.7 сая төгрөгийн ХАОАТ-ыг суутгасан олгосон ба 2.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт дутуу төвлөрүүлсэн, мөн аймгийн Засаг даргын 2024 оны А/271 дүгээр захирамжийн дагуу орон нутгийн хамгаалалтын хээрийн дадлага сургалтын зардалд 1.0 сая төгрөгийг анхан шатны баримтгүй шилжүүлсэн тул төлбөрийн акт тогтоосон.
- Баянбулаг сумын ЗДТГ нь “Сайн амгалан аривжих” хийдэд сумын ноён нуруу засуулах хурал ном хуруулж 0.6 төгрөгийн төсвийг зориулалт бусаар зарцуулсанд төлбөрийн акт тогтоосон.
- Аймгийн ЗДТГ нь аймгийн Засаг даргын 2024 оны А/736 дугаар захирамжаар Баянхонгор аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 131/ШШ2024/00673 дугаар захирамжийн дагуу 1 иргэний ажилгүй байсан хугацааны НДШ, ЭМД-ын шимтгэл болох 3.6 сая төгрөг төлсөнд албан шаардлага хүргүүлсэн байна.
- Шинэжинст сумын ЗДТГ-ын даргын 2024 оны А/20 дугаар тушаалаар Сэгс цагаан богд заставд 10.0 сая төгрөгийн өртөгтэй Старлинг жен 3 тоног төхөөрөмж худалдан авч өгсөн ба тухайн хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгээгүй, цаашид тухайн хөрөнгийн засвар үйлчилгээтэй асуудлыг хэн хариуцах талаар тодорхойгүй тул албан шаардлага хүргүүлсэн.
- Санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгаж тайлагнаагүй байхад Шинэжинст сумын ЗДТГ 2.6 сая, Бөмбөгөр сумын ЗДТГ 4.5 сая, нийт 7.1 сая төгрөгийг зарцуулсанд албан шаардлага хүргүүлсэн.
- Галуут сумын ЗДТГ нь Засаг даргын нөөц хөрөнгөөс 5.5 сая төгрөгийн баяр наадмын зардал зарцуулсанд албан шаардлага хүргүүлсэн.
- Баацагаан сумын ИТХ-ын 2024 оны 16/02 дугаар тогтоолоор ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 138.1 сая төгрөг оруулахаар төлөвлөж 100.8 сая

төгрөгийн орлого төвлөрсөн бөгөөд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 136.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 66.0 сая төгрөгийг зарцуулсан боловч зориулалтын дагуу зарцуулаагүй тул зөвлөмж хүргүүлсэн.

Мөн бараа үйлчилгээний бусад зардлаас уралдаан тэмцээний зардал, бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, автомашины сэлбэг засварт зарцуулсан, 1 удаагийн мөнгөн шагнал урамшуулал, 1 удаагийн тэтгэмж олгосон, төрийн албан хаагчдын туршлага судлах аяллын зардалд зарцуулсан зэрэг зөрчлүүд илэрснийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчилд оруулсан болно.

4. Орон тооны судалгаа.

Орон тооны судалгаанд Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн харьяа 50 төсөвт байгууллага хамрагдсан ба төсвийн гүйцэтгэлийн тайлангаар цалингийн зардалд 25,266.7 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 24,202.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд 922 орон тоотой ажиллахаар төлөвлөснөөс 925 орон тоотой ажиллаж 3 орон тоогоор илүү ажилласан байна.

Нийт орон тоонд удирдах ажилтан 24.1 хувийг, гүйцэтгэх ажилтан 50.9 хувийг, үйлчлэх ажилтан 14.9 хувийг, 10.4 хувийг гэрээт ажилтан эзэлж байна.

Төрийн албан хаагчийн албан тушаалын ангиллаар 37.3 хувийг төрийн захиргааны албан хаагч, 0.4 хувийг төрийн тусгай албан хаагч, 33.4 хувийг төрийн үйлчилгээний албан хаагч, 10.4 хувийг гэрээт ажилтан, 18.4 хувийг улс төрийн албан хаагч эзэлж байна.

Хүснэгт 23. Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын орон тооны төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Төрийн албан хаагчийн ангилал	Ажиллагсдын тоо		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Удирдах ажилтан	223	223	0
2	Гүйцэтгэх ажилтан	468	471	3
3	Үйлчлэх ажилтан	138	138	0
4	Гэрээт ажилтан	93	93	0
Дүн		922	925	3
1	Төрийн захиргаа	348	345	-3
2	Төрийн тусгай	4	4	0
3	Соёл урлагын салбарын төрийн үйлчилгээний албан хаагч /ТҮСУ/	0	1	1
4	Төрийн үйлчилгээ	305	309	4
5	Гэрээт ажилтан	95	96	1
6	Улс төрийн албан хаагч	170	170	0
Дүн		922	925	3

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны Төсвийн гүйцэтгэлийн тайлан болон Ерөнхий чиглэлийн судалгаа

Сумдын ЗДТГ-ын орон тоо нь харилцан адилгүй байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 13 дугаар тогтоол “Сумын ЗДТГ-ын орон тооны хязгаарыг тогтоох тухай” тогтоолоор хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, үйлчлэх өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоог харгалзан сумын Засаг даргын Тамгын газрын орон тоог тогтоож өгсөнтэй холбоотой байна.

Харин сумын ИТХ-ын орон тоог Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 376 дугаар тогтоолоор “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны бүтэц, аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны орон

тооны хязгаарыг тогтоох тухай” тогтоолоор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг 3 хүртэл байхаар тогтоож өгсөн байна.

Судалгаагаар 2 байгууллага батлагдсан орон тоог нийт 4 орон тоогоор хэтрүүлэн ажилласан, 1 байгууллага 1 орон тоог хэмнэн ажилласан байна.

Аймгийн ТЕЗ-ийн харьяа Сум дундын ойн анги, Санхүүгийн хяналт дотоод аудитын алба, Байгаль орчны газар, Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн өмчийн газар, ахмад настны Асрамжийн төв нь батлагдсан орон тооны хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

- Галуут сумын ИТХ-ын ажлын алба нь 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Галуут сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын Б/04 дүгээр тушаалаар жолоочийг түр томилсон бөгөөд 2024 оны 10 дугаар сар хүртэл ажилласан байна
- Баянлиг сумын ЗДТГ нь 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар “Орон тоо, цалингийн санг шинэчлэн батлах тухай” тушаалдаа 3 орон тоог илүү баталж ажилласан байна. Тухайлбал, цахилгаанчин, үйлчилгээний оператор, хүний нөөцийн ажилтан, галлагч зэрэг орон тоог нэмж батлан ажилласан

БҮЛЭГ 5. ЗАРИМ АЛБАН ТУШААЛТАН ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ МӨРДӨЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Монгол Улсын Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан. Энэхүү хуулийн гол зорилго нь төрийн байгууллагуудын үйл ажиллагааг үр ашигтай, ил тод, хэмнэлттэй болгох, төсвийн сахилга батыг хангах, үрэлгэн зардлыг бууруулахад чиглэгдсэн.

Хууль батлагдсанаас хойш хоёр удаа нэмэлт, 4 удаа нэмэлт, өөрчлөлт орсон ба хамгийн сүүлийн 2024 оны 12 дугаар сарын 17-нд орсон нэмэлт, өөрчлөлт нь 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөж байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын харьяаны төсвийн шууд захирагчийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хослуулан шалгахад 16 байгууллагад 188.1 сая төгрөгийн 17 зөрчил илэрлээ. Үүнээс 6.6 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 158.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 12 албан шаардлага өгч, 20.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, 3.2 сая төгрөгийн 1 зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлсэн. Үүнд:

5.1.Төрийн хэмнэлтийн хуулийн 6 дугаар зүйл.Тээврийн хэрэгсэл

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 95/280 дугаар хамтарсан тушаалаар “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ыг баталж бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт мөрдөж ажиллахыг үүрэг болгосон байна.

Тайлант онд Баянговь сумын ЗДТГ-ын хөрөнгөд сумын Засаг даргын албан хэрэгцээнд ашигладаг 55.0 сая төгрөгийн өртөгтэй Lexus 470 автомашин бүртгэлтэй, тус тээврийн хэрэгслийг ашигладаг байхад төсвийн хөрөнгөөр УАЗ пургон автомашин худалдан авсан зөрчил илэрсэнд ТШЗ-д зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

Өмнөх аудитаар аймгийн Засаг даргын харьяа 24 байгууллагын 75 тээврийн хэрэгслийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасан бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар сольж, зөрчлийг

арилгах албан шаардлагыг хүргүүлсэн ба 22 ширхэг тээврийн хэрэгсэл улсын дугаараа солиогүй хэрэгжилт 71 хувьтай байна.

Мөн Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байхад 5 сумын 209.7 сая төгрөгийн балансын үнэ бүхий 78 тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлээгүй зөрчил илэрсэн тул тус тогтоолын дагуу татан төвлөрүүлэх, тогтоолыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгсөн.

Татан төвлөрүүлээгүй 78 тээврийн хэрэгслээс өмнөх онд 2 тээврийн хэрэгслийг аймгийн ИТХ-ын даргын захирамжаар акталж, 6 тээврийн хэрэгслийг эзэмшигч байгууллагаас хүлээлгэн өгөөгүй, хэрэгжилт 76.8 хувьтай дутуу хэрэгжсэн байна.

Дээрх 2 зөрчлийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг ОНӨГ-т өгсөн ба газрын дарга солигдсон, зарим тээврийн хэрэгсэл ашиглах боломжгүй, актлахаар санал хүргүүлсэн зэрэг шалтгаанаас хугацаандаа бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

Өмнөх онуудад суудлын авто машиныг хамруулан аудитын горим сорил хэрэгжүүлдэг байсан бол “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” сэдэвт нийцлийн аудитаар Баянхонгор аймгийн хэмжээний (боломжит бүх мотоцикл, суудлын бус машин механизм) нийт 26,124.1 сая төгрөгийн 888 тээврийн хэрэгслийг хамруулсан ба хэрэгжилтийн тус аудитаар авч үзэхээр шийдвэрлэсэн.

5.2.Төрийн хэмнэлтийн хуулийн 8 дугаар зүйл. Дүрэмт хувцас

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчин Шинэжинст сумын ЗДТГ сумын Засаг даргын 2024.12.18-ны өдрийн А/129 дүгээр захирамжаар сумын онцгой комисс, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний дадлага хувцас бомборын зардалд 4.2 сая төгрөгийг зарцуулсанд төлбөрийн акт тогтоосон.

5.3.Төрийн хэмнэлтийн хуулийн 12 дугаар зүйл. Бусад хангамж

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийг зөрчсөн 22.6 сая төгрөгийн 3 зөрчил илэрч 2.4 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 20.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнд:

- Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх “Үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал” гэсэн заалтыг зөрчин Баянцагаан сумын ИТХ 0.2 сая төгрөгийн гар утасны нэгжийн үнийг 4 албан хаагчид олгосон тул төлбөрийн акт тогтоосон.
- 12.1.4 дэх “хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэсэн заалтыг зөрчин Баацагаан сумын ЗДТГ ажлаас түр чөлөө авсан албан хаагчид 2 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжид 2.2 сая төгрөг олгосныг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон,
- 12.1.4 дэх “хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэсэн заалтыг зөрчин аймгийн ЗДТГ аймгийн Засаг даргын 2024.01.25-ны өдрийн А/35 дугаар захирамжаар төрийн албан хаагчдыг туршлага судлуулах, аяллын зардалд Засаг даргын нөөц хөрөнгөөс 2024.01.26-ны өдөр "Мазаалай номадик тур" ХХК руу 20.2 сая төгрөгийг шилжүүлсэн тул зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

5.4.Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйл.Хэмнэлтийн бусад арга хэмжээ

СТА-аар аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг зөрчсөн 106.2 сая төгрөгийн 12 зөрчил илэрч 3.2 сая төгрөгийн 1 зөрчлийг иргэний ирүүлсэн годол мэдээллийн дагуу хуулийн байгууллагад шилжүүлж, 103.0 сая төгрөгийн 11 зөрчилд албан шаардлага өгсөн байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.8 дахь заалтыг зөрчсөн 40.5 сая төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага өгсөн.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалтыг зөрчсөн 65.7 сая төгрөгийн 7 зөрчил илэрснээс 62.5 сая төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага, 3.2 сая төгрөгийн 1 зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлэн ажилласан.

Хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалтыг зөрчсөн 7 зөрчлөөс аймгийн ИТХ болон 4 сумын ИТХ-аас Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгууль болсонтой холбогдуулан иргэдийн төлөөлөгч нарт хүндэтгэл үзүүлэхэд зориулан бэлэг дурсгалын зүйл, мөнгөн аяга авахад 51.2 сая төгрөгийг зарцуулсан нийтлэг 5 зөрчил илэрсэн байна.

Хүснэгт 24. Хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зөрчлийн нэгтгэл (сая.төг)

Хуулийн заалт	Зөрчил гаргасан байгууллагын тоо	Албан шаардлага		Зөвлөмж		Төлбөрийн акт		Хуулийн байгууллагад шилжүүлсэн		Нийт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
15 дугаар зүйлийн 15.1.3.	3	3	35.5							3	35.5
15 дугаар зүйлийн 15.1.5.	7	6	62.5					1	3.2	7	65.7
15 дугаар зүйлийн 15.1.8.	2	2	5.0							2	5.0
Дүн	12	11	103.0					1	3.2	12	106.2

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

БҮЛЭГ 6. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

6.1.Засаг даргын Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Баянхонгор аймгийн Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг байршуулах хуулийн хугацаа болоогүй байна.

Хүснэгт 25. Шилэн дансны мэдээлэл

Д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээ-лээгүй	Хугацаа болоогүй	Хугацаа хоцорч байршуулсан мэдээллийн агуулга
1	Бүтэн жил	12	12	8	1	-	3	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн.

2	Харас жил	1	1	1	-	-	-	-
3	Сар бүр	6	72	65	7	-	-	ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг 5, 7, 8 дугаар саруудад, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг 2 дугаар сард, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг 7, 8 дугаар саруудад, Засаг даргын төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 12 дугаар сарын мэдээг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.
4	Тухай бүр	6	72	72	-	-	-	-
Нийт		25	157	146	8	-	3	

Эх сурвалж. Баянхонгор аймгийн Засаг даргын шилэн дансны цахим хуудас

Аудитын илрүүлэлт:

- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэртэй холбоотойгоор Баянхонгор аймгийн Засаг даргын 222 захирамж байршуулж мэдээлэхээс 100 захирамжийг мэдээлж, 122 захирамж буюу мэдээлэх ёстой мэдээллийн 55%-ийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг зөрчсөн байна Иймд шилэн дансны мэдээллийг нөхөн мэдээлэх албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын даргад хүргүүлэв.

Өмнөх оны аудитаар илрүүлсэн Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй 3 гэрээнээс 2 гэрээг ("Монгол болгар гео" ХХК, Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ) нөхөн байршуулж ажилласан байна.

6.2.СТА-аар илэрсэн Шилэн дансны зөрчил

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2-т хамаарах орон нутгийн өмчит 114 төсөвт байгууллага, 3.1.3-т хамаарах орон нутгийн өмчит 5 аж ахуйн нэгж, 3.1.5-т хамаарах төсвөөс санхүүжилт авч байгаа, 4 өрхийн эмнэлэг, нийт 123 төсвийн байгууллага, аж ахуйн нэгж шилэн дансны нэгдсэн портал системд бүрэн хамрагдаж, мэдээллийг байршуулж иржээ.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 -д заасан мэдээллийг дээрх байгууллагууд шилэн дансны нээлттэй цахим хуудсанд хугацаанд нь, ил тод байршуулсан эсэхийг нотлох зүйлсэд үндэслэн тулган шалгаж дараах зөрчлийг илрүүлсэн. Үүнд:

- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагыг бүрэн мэдээлээгүй,
- Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан,
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг үнэн зөв, цаг хугацаанд нь бүрэн мэдээлээгүй зэрэг зөрчлүүд нийтлэг илэрч байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын Шилэн дансны цахим хуудаст мэдээлсэн байдлыг шалгахад аудитаар аймгийн Засаг даргын харьяа 18 байгууллагад 1,930.5 сая

төгрөгийн 18 зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах 18 албан шаардлагыг хүргүүлж ажилласан байна. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 1,527.7 сая төгрөгийн 177 гүйлгээний мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэртэй холбоотойгоор 5 байгууллага нийт 42 шийдвэр болон гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй.
- Шилэн дансны нэгдсэн системд 2 байгууллага 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Дээрх зөрчилд санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага хүргүүлсэн байна.

БҮЛЭГ 7. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ТӨЛБӨРИЙН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,455.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 127.4 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 4.6 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 1,724.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага өгч, 598.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 7 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ нь өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөөг аймгийн ЗДТГ-ын даргын 2024.05.21-ний өдрийн 2/807 дугаар албан бичгээр ирүүлж, зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжилтийг аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 1а/707 дугаар албан бичгээр гаргаж ирүүлсэн байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн 2023 оны аудитаар өгсөн зөвлөмжийг гарсан алдаа зөрчилтэй харьцуулан үнэлэхэд зөвлөмжийн биелэлт 100.0 хувьтай үнэлэгдэж байна.

Хүснэгт 26. Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт

№	Аудитаар өгсөн албан шаардлага	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн утга, биелэлт	
Аймгийн ИТХ-д толилуулах нь:			
1	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг хэт жижиглэн батлахгүй байх асуудлыг анхаарч үзнэ үү.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	"ОНХС-ийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө"-д аудитаар өгсөн зөвлөмжийг 2024.07.02-ны өдрийн 1/405 дугаар албан бичгээр хүлээн авч цаашид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө төсөл арга хэмжээг хэт жижиглэхгүйгээр төлөвлөлтөө зөвлөмжийн дагуу хийж 2025 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийж хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөгөөний төслөө аймгийн ИТХ-д өргөн барьсан. Мөн Монгол ардын нам, Ардчилсан намын бүлэг дээр төсөл арга хэмжээний төслөө танилцуулахдаа давхар аудитын зөвлөмж дүгнэлтийг танилцуулсан.
		Аудитаар тооцсон биелэлт	Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг хэт жижиглэн баталж байгаа зөрчил засагдахгүй байна. Иймд сумдын ИТХ-д уг зөрчлийг таслан зогсоох чиглэл өгөхийг аймгийн ИТХ-д толилуулахаар шийдвэрлэв.

	Баянхонгор аймгийн Засаг даргад		
1	Аймгийн Засаг даргын харьяа байгууллага, сумдын Засаг дарга нарын Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлтийг аймгийн хэмжээнд нэгтгэн, дүн шинжилгээ хийж, Төрийн аудитын байгууллагад ирүүлж байх	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгдсэн тайланг хүлээн авахдаа хөтөлбөр, хүрэх үр дүнгийн тайланг төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр гаргуулан хүлээн авч нэгтгэсэн.
		Аудитаар тооцсон биелэлт	Аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын 2024 оны эхний хагас жилийн тайланг авахдаа хөтөлбөр, хүрэх үр дүнгийн тайланг хүлээн авсан байна. Гэвч СТА-аар 12 сумын ТТЗ хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар тайлагнасан хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлтийг ирүүлээгүй тул албан шаардлага хүргүүлсэн байна. Биелэлт 60%
2	Аймгийн ИТХ-аар баталсан төсөл арга хэмжээний зардлыг Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг дагуу олгож байх	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Аймгийн ИТХ-аар 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд баталсан төсөл, арга хэмжээний зардлын санхүүжилтийг батлагдсан төсвийн хүрээнд хяналт тавьж олгоно.
		Аудитаар тооцсон биелэлт	Аймгийн ИТХ-аар 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд баталсан төсөл, арга хэмжээний зардлын санхүүжилтийг батлагдсан төсвийн хүрээнд хяналт тавьсан байна. Биелэлт 100%
3	Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ"-ний хэрэгжилтийг дүгнэж, аймаг, сумдын ИТХ-д тайлагнаж байх	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүдийн 2022-2023 онуудад "Байгаль орчныг хамгаалах, уул уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх тухай" 7 аж ахуй нэгжийн гэрээг дүгнэв. Гэрээ байгуулсан уул уурхайн аж ахуйн нэгжүүдэд гэрээний хэрэгжилтийг гарган ирүүлэх талаарх албан бичгийг хүргүүлсэн. "Эрдэнэ Монгол" ХХК-тай байгуулсан гэрээний хэрэгжилтийг 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 62/24 дүгээр албан бичгээр ИТХ-д хүргүүлсэн.
		Аудитаар тооцсон биелэлт	Гүйцэтгэлийн аудитаар албан шаардлага өгсөн тул зөвлөмжийг аудитын зөвлөлөөр хэлэлцэн хаасан. Уул урхайн аж ахуйн нэгжийн гэрээг 2025 оны 5 сард дүгнэдэг гэх тайлбарыг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ өгсөн. 2024 оны байгуулсан гэрээг 2025 оны 05 дугаар сард дүгнэхээр байна. Биелэлт 80%
4	Аймаг, сумдын ОНХС-ийн орлого, зардлын бүртгэлийг мөрдөж буй НБББББ-т тодорхой тусган, бүртгэл хөтөлөлтөд тавих хяналтыг сайжруулах	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Найдваргүй зураг төсвийн авлагыг Аймгийн ИТХ-аар оруулан тухайн барилга байгууламжийн өртгийг нэмэгдүүлэх замаар авлагыг бууруулна. ОНХС-аас хийгдэх 7 төсөл арга хэмжээний 521.5 сая төгрөгийг 2024.09.16-ны өдрийн аймгийн ИТХ-ын 21 дүгээр хуралдаанаар төсөвт тодотгол хийж өрийг барагдуулахаар аймгийн ИТХ-ын 21/06 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралтын 1.5, 1.13, 1.15, 1.18, 1.19, 1.20, 1.21 дээр тус тус батлуулсан.

		Аудитаар тооцсон биелэлт	ОНХС-аас хийгдэх 7 төсөл арга хэмжээний 521.5 сая төгрөгийг өр төлбөрийг барагдуулахаар батлуулсан байна. Биелэлт 70%
5	Хандивын орлогын төлөвлөгөөг Сангийн яамны Э-тайланд үнэн зөв оруулах	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Сангийн яаманд Баянхонгор аймгийн санхүүгийн нэгдсэн тайлан тушаахдаа засварласан.
		Аудитаар тооцсон биелэлт	Сангийн яаманд санхүүгийн тайлан нэгтгүүлэхдээ засварласан байна. Биелэлт 100%
6	Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга, “Айети Юнипикэшн” ХХК-ийн хооронд байгуулсан “Виртуал студийг менежментээр хувьчлах гэрээ”-ний дагуу зээлийн эргэн төлөлтийг хугацаанд төлөөгүй зөрчил өмнөх аудитаар илэрч төлбөрийн акт тогтоосон байхад барагдуулаагүй тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэх	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Аудитаар өгсөн төлбөрийн актыг “Айети Юнипикэшн” ХХК-аар төлүүлсэн
		Аудитаар тооцсон биелэлт	Төлбөрийн актыг 2024.09.24-ний өдөр барагдуулсан байна. Биелэлт 100%
Аймгийн Татварын газарт			
1	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтод тавих хяналтыг сайжруулж, аймгийн ЗДТГ-ын СТСХ-тэй хамтран ажиллах уялдаа, холбоог сайжруулах	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Тайлант 2024 оны төсвийн жилд ажлын уялдаа холбоог сайжруулж Баянхонгор аймгийн татварын газрын А/15 дугаар тушаалаар 2023 оны хувь хүний орлогын албан татварын буцаан олголтыг 1,049,936,070.93 төгрөгөөр баталж, Санхүү, төрийн сангийн хэлтсээс 1,049,936,070.93 төгрөгийг жагсаалтын дагуу 100 хувь олгосон байна.
		Аудитаар тооцсон биелэлт	Ажлын уялдаа холбоотой ажиллаж, татварын орлогыг тооцоо нийлж баталгаажуулсан байна. Биелэлт 100%
БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ			100%

Эх сурвалж: Байгууллагын ирүүлсэн албан бичиг, Санхүүгийн тайлан FAS системд оруулсан биелэлт

БҮЛЭГ 8. БАЯНХОНГОР АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ АЙМГИЙН ИТХ ХҮЛЭЭН АВСАН БАЙНА.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн төсөлд тусгагдсан төсвийн суурь орлогыг 3,245.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх 7 санал, суурь зарлагыг 790.0 сая төгрөгөөр бууруулах 1 санал, төсвийн үр ашгийг 2,480.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх 5 санал, нийт 6,515.4 сая төгрөгийн 13 саналыг хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 1ө/340 дүгээр албан бичгээр төсвийн төсөлд тусгагдсан орлого нэмэгдүүлэх, зарлага бууруулах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх 6,515.4 сая төгрөгийн бүх саналыг хүлээн авсан байна.

Аудитаар нийт 4,378.7 сая төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрч, 143.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 888.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага өгч, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 3,347.3 сая төгрөгийн 2 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүллээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО”-ын 10 зорилтыг тусгасан ба аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжилт гарах хугацаа болоогүй байна.
2. Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгагдсан 4 төсөл, арга хэмжээнд улсын төсвөөс 6,161.7 сая, орон нутгийн төсвөөс 57.0 сая нийт 6,248.7 сая төгрөгийг тусган хэрэгжүүлж байна.
3. Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу, сумдын засаг дарга нарын гүйцэтгэлийн тайланд хөтөлбөрийн зорилт, үр дүнг тоон болон чанарын шалгуураар тодорхойлж, цаашдын хэрэгжилтэд хяналт тавих шаардлагатай байна.
4. Аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн төсөлд хандив тусламжийн орлогыг төлөвлөхгүй байх зөвлөмж өгсөн байхад хандивын орлогыг 5,857.9 сая төгрөг оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 2,510.7 сая төгрөг орж 3,347.3 сая төгрөгийн эх үүсвэр дутагдсан байна.
5. Төрийн албан хаагчдын цалингийн өсөлт болон “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2024 оны ногдол ашиг хуваарилсан зэрэг нь татварын орлого 6,043.6 сая төгрөгөөр давуулан биелэхэд голлон нөлөөлсөн байна.
6. Аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд 108,785.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас, 91,829.2 сая төгрөгийг зарцуулж, 16,956.6 сая төгрөг хэмнэгдсэн байна. Энэхүү хэмнэлт нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал, бараа үйлчилгээний бусад зардал, хөрөнгийн зардал зэрэг голлох нөлөө үзүүлж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн доорх албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Нэг. Баянхонгор аймгийн ИТХ-д толилуулах нь

Аймгийн ИТХ-аар баталсан 2024 оны орон нутгийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын зардал болон хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан хөрөнгө оруулалтын хэмжээ хооронд 197.2 сая төгрөгийн зөрүү гарсан нь баримт бичгүүдийн уялдаа холбоог сайжруулах шаардлагатайг харуулж байгаад анхаарлаа хандуулна уу.

Хоёр. Баянхонгор аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан танаа

1. Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу сумдын Засаг дарга нарын гүйцэтгэлийн тайланг хөтөлбөрийн зорилго, зорилт болон хэрэгжилтийн үр дүнг тоон болон чанарын шалгуураар тодорхой тусгаж, тайлангийн хэрэгжилтэд бодитой хяналт тавихын зэрэгцээ тайлагнах чадавх, мэдээлэл боловсруулах ур чадварыг дээшлүүлэх сургалт, арга зүйгээр сумдын төрийн албан хаагчдыг үе шаттайгаар хангах
2. Орон нутгийн татварын болон татварын бус орлогыг тухайн жилийн онцлог нөхцөл байдал, эдийн засгийн хандлагатай уялдуулан бодитоор төлөвлөж, эх үүсвэр нь тодорхой бус хандивын орлогыг төсөвт тусгахгүй байх

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын

байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу, зөвлөмжийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт 2025 оны 11 дүгээр сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ҮАГ-ЫН САНХҮҮ -НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

Баянхонгор аймгийн сумдын Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авах шалгуур хангасан хоршооны тоо 2023-2024 онд буурч, 2024 онд хэрэгжсэн “Шинэ хөдөө” төслийн хүрээнд хоршооны гишүүд арилжааны банкнаас бага хүүтэй зээлд хамрагдсантай холбоотойгоор тайлант онд 13 төсөл арга хэмжээнд 528.7 сая төгрөгийн зээл олгогдож, улмаар 1,848.4 сая төгрөгийн хөрөнгийг жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон хоршооны гишүүдэд олгох боломж алдагдсан байна.

Цаашид Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох журамд өөрчлөлт оруулах замаар орон нутагт шинэ үйлдвэрлэл бий болгох, жижиг, дунд үйлдвэрлэлийг өргөжүүлэх, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх саналыг холбогдох яамдад хүргүүлэхийг Үндэсний Аудитын газрын Санхүү-Нийцлийн Аудитын газарт уламжлав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, аймгийн Орон нутгийн өмчийн газар, Татварын газрын хамт олонд талархал илэрхийлье.

оОо